

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-44</i>
<hr/>	
<i>1. Малын хорогдол болон малчдад үзүүлж байгаа даатгалын үйлчилгээний талаарх мэдээлэл сонсох</i>	<i>4-28</i>
<i>2. “Монгол Улсын Олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан</i>	<i>28-44</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 45 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Х.Болорчулуун, Б.Бейсен, Ц.Туваан, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Г.Мөнхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Цэрэнпунцаг.

Нэг.Малын хорогдол болон малчдад үзүүлж байгаа даатгалын үйлчилгээний талаарх мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Нарантуяа, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга З.Батболд, мөн газрын ахлах референт Н.Батцэцэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх Б.Жавхланцогт, Малын индексжүүлсэн даатгалын ахлах мэргэжилтэн Д.Мөнхбилэг, Үндэсний давхар даатгал ХК-ийн захирал Б.Жавхланта нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Малын хорогдол болон малчдад үзүүлж байгаа даатгалын үйлчилгээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг мэдээлэл хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар 11 цаг 56 минутаас 13 цаг 23 минутад хуралдааныг даргалав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Г.Ганболд, Д.Өнөрболор, Н.Наранбаатар, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуулгад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Нарантуяа, Үндэсний давхар даатгал ХК-ийн захирал Б.Жавхланта нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, Д.Өнөрболор, Г.Ганболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Малын хорогдол болон малчдад үзүүлж байгаа даатгалын үйлчилгээний талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ш.Цэрэндулам, мөн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Буяннэмэх, мөн газрын Хог хаягдлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн А.Оюун, Химийн бодис хариуцсан шинжээч Ц.Батжаргал, Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын амьтны асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Мөнхдөш, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн Олон талт хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Д.Ариунтуяа, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хэрэгжилтийн үндэсний тайлан, илтгэл боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх төслийн зохицуулагч Х.Ундармаа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Гадаад хамтын ажиллагааны тасгийн дарга Ө.Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Монгол Улсын Олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Д.Өнөрболор, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ш.Цэрэндулам, мөн яамны Химийн бодис хариуцсан шинжээч Ц.Батжаргал, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн Олон талт хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Д.Ариунтуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 48 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
11 цаг 45 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Саранчимэг: Эрхэм гишүүдийнхээ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгэхээр Байнгын хорооны гишүүдийн олонх ирж ирц 52,6 хувьтай болсон тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 6 сарын 20-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Гочоогийн Ганболд гишүүн ирсэн байна. Наянтайн Ганибал гишүүн ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор ирсэн байна. Батсүхийн Саранчимэг гишүүн ирсэн. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ирсэн байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн байна.

Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Малын хорогдол болон малчдад үзүүлж байгаа даатгалын үйлчилгээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох байгаа. Ажлын хэсгийнхнийг оруулж байгаарай.

2-т Монгол Улсын олон талт олон улсын гэрээ гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг сонсох байгаа. Ийм 2 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудал байхгүй байгаа учраас хэлэлцэх асуудлаа баталлаа.

Эхний асуудалдаа оръё. Малын хорогдол болон малчдад үзүүлж байгаа даатгалын үйлчилгээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох байгаа.

Өнөөдөр сайд бас гадаадад томилолттой байгаа учраас мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ганхүлэг танилцуулна. 1 номерын микрофоныг өгье.

М.Ганхүлэг: Байнгын хорооны дарга, гишүүддээ өдрийн мэндийг хүргэе ээ.

Болорчулуун сайд гадаадад бас томилолттой байгаа учраас миний бие төлөөлөн оролцож байна.

Улсын хэмжээнд 2022-2023 онд нийт 190,2 мянган малчин өрхөд 71,1 сая малд өвөлжиж, манай улсын мал сүрэг одоогийн байдлаар 17 сая төлөөр өсөн 3,1 сая том малын зүй бус хорогдол гараад байна. Өнгөрсөн өвөл 15 аймгийн 64 сум цагаан зудтай, 100 орчим сум харын зудтай өвөлжиж, хавартаа олон удаагийн хүчтэй салхи шуургатай хүндхэн өвөл хаврыг давлаа.

Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлыг Монгол Улсын Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын ахлуулсан ажлын хэсэг газар дээр нь ажиллан танилцаж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг Улсын онцгой комисс, Засгийн газрын хуралдаануудад 6 удаа танилцуулан улсын нөөцийн өвс тэжээл хөнгөлөлттэй

үнээр олгох, малчдад эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд зориулан туулах чадвар сайтай автомашин, гэр, хүнс, шатахууны дэмжлэг үзүүлэхэд нийт 7,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлээ.

Мөн олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, 21 аймаг, Нийслэлийн 2 дүүргийн 14785 өрх өгөхөд бэлэн мөнгө, өвс тэжээл, хүнс, хүүхэд, эмэгтэйчүүдийн багц зэрэгт 8 тэрбум төгрөгийн эд зүйлсийн дэмжлэгийг үзүүлсэн байна. Энэ онд 27 сая эх малын 19,4 сая эх мал төллөж, 17 сая мал бойжиж байгаа нь хязгаарлалттай нийлүүлэг хээл хаялт, төлийн хорогдол өмнөх онуудаас өндөр байгааг харуулж байна. Улсын хэмжээнд 19,4 сая төл хүлээн авч, 17 сая төл бойжиж, бойжилт 88,2 хувьтай байна. Том малын зүй бус хорогдол 3,1 сая, үүнээс тэмээ 2,6 мянга, адуу 178,2 мянга, үхэр 270,5 мянга, хонь 1,3 сая, ямаа 1,3 сая зүй бусаар хорогдсон нь оны эхний нийт малын 4,4 хувийг эзэлж байна. Малын зүй бус хорогдол хамгийн их болох Архангай аймаг 534,7 мянга, Хэнтий аймаг 490,9 мянга, Сүхбаатар аймаг 475 мянга, Увс аймаг 303,5 мянга, Завхан аймаг 205,1 мянга зэрэг аймгуудад нийтдээ 2 сая мал хорогдсон нь нийт хорогдлын 63,4 хувийг эзэлж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 1 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 141 дүгээр тушаалын хэрэгжилтийг зохион байгуулан улсын хэмжээнд зүй бусаар болон гамшигийн улмаас хорогдсон мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах, хашаа хороо, бууц, худаг, ус цэгүүдийг халдваргүйтгэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 2,7 сая толгой малын 10 мянган амьтны хүүр, сэг зэвийг устгалд оруулж 79 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мал амьтны гоц халдварт өвчний халдварын тархалтыг зогсоох, эрсдэлийг

бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх халдваргүйжлийн арга хэмжээнд нийт 9.7 сая м² талбайд ойролцоогоор 10 мянган хашаа хороо, 1801 худаг уст цэг, 914 нийтийн эзэмшлийн талбай, 4239 түүхий эд бэлтгэх цэг зэрэг зорь, агуулах, тэжээлийн объектуудад бас халдваргүйжлийн үйл ажиллагааг явуулсан байна.

Хорогдсон мал, амьтны сэг зэмийн устгал мал эмнэлгийн халдваргүйжлийн арга хэмжээнд орон нутгийн байгууллага, малчид, мал бүхий иргэд зэрэг нийтдээ 6500 орчим хүн хүчний нөөцтэй бол ажилласан байна. Сэг зэм устгалд зориулж хорогдол ихтэй 9 аймаг, нийслэлд 104 сая төгрөгийн хлорын шохой, 20 сая төгрөгийн шатахуун, 3 сая төгрөгийн халдвар хамгааллын хувцас, 5 сая төгрөгийн халдваргүйжлийн багаж хэрэглэгдэхүүн нэмэлтээр олголоо.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Төрийн нарийн бичгийн даргын А/269 дүгээр тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч даргын 2023 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн удирдамжаар Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад цаг уурын аюулт үзэгдлийн дараах хохирлын үнэлгээ хийж байна.

Өвөлжилт хаваржилтын явцад нийт малд 50 ба түүнээс дээш хувиар хорогдсон малчин болон мал бүхий өрхийн судалгааг Архангай, Завхан, Увс, Төв, Хэнтий, Сүхбаатар аймгийн болон нийслэлээр гарган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал Архангай аймгийн Эрдэнэбулган, Өгий нуур, Жаргалант гэсэн 3 сумын 51 малчин болон мал бүхий өрхөд 12 мянган толгой малаас 7011 толгой мал буюу 55 хувь нь хорогдсон ийм бас байдал байгаа. Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумын 23 малчин болон мал бүхий өрхөд 8857 мянган толгой мал тоологдсоноос 4522

толгой мал буюу 51,1 хувь нь хорогдсон ийм бас тоон мэдээ байна. Хэнтий аймгийн Батишрээт, Батнуруу, Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Баянмөнх, Хэрлэн, Мөрөн зэрэг 7 сумын 101 малчин болон мал бүхий өрхөд 20 мянган мал тоологдсоноос 14 мянган толгой мал буюу 70,5 хувь нь бол хорогдсон. Нийтдээ 50 хувиас дээш хорогдолтой 6 аймгийн 39 сум, 1 дүүрэг 2100 малчин өрх байна. Үүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Засгийн газрын хуралдаанд танилцуулан хариу арга хэмжээ авах, амьжиргааг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Өнөөдрийн бас гол асуудал малын индексжүүлсэн даатгалтай холбогдолтой мэдээллийг танилцуулъя. Малчдын амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийн байгаль цаг уурын эрс тэс нөхцөлөөс үүдэлтэй ихээхэн хэмжээний гамшигийг хохирол багатайгаар даван туулах бодит боломжоор хангагдах даатгалын үйлчилгээг малын индексжүүлсэн даатгалаар хэрэгжүүлж байна. Дэлхийн банкны санхүүжилтээр 2006 оноос малын индексжүүлсэн даатгал төсөл эхэлж, 2014 оныг дуустал хэрэгжиж, 21 аймгийг хамарсан малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог бий болгож чадсан. Улмаар 2014 онд малын индексжүүлсэн даатгалын хууль батлагдаж, Үндэсний давхар даатгал компани хариуцан ажиллаж байна. Даатгалын онцлог нь бол 1 малчны хотонд гарсан хохирлоос бусад сумын хэмжээнд гарсан хохирлоос тооцож нөхөн төлбөр олгодог. Хэрвээ тухайн жил сумд их хэмжээний мал хорогдсон ч тухайн хот онд мэнд орсон тохиолдолд мөн л адил даатгалын нөхөн төлбөр авах боломжтой. Гэвч зөвхөн тухайн хотонд л хорогдол үүссэн бол нөхөн төлбөр олгох боломжгүй юм. Энэ нь малчдыг хариуцлагажуулж буй хэлбэр юм.

Малын индексжүүлсэн даатгалд дараах төрлийг сонгон даатгуулсан хорогдолд нөхөн төлбөр олгодог. Зуд,

өвчин эмгэг, чоно, нохойд бариулах, хулгайд алдах. Малын индексжүүлсэн даатгал хэрэгжиж эхэлснээс хойш 16 жил, Үндэсний даатгал компани байгуулснаас 7 дахь жилдээ 21 аймаг, 330 сум, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 9 даатгалын компани 2611 төлөөлөгч, зуучлалаар Төрийн банк, Хаан банк оролцон үйл ажиллагаа явуулж байна.

Би товчлоод 2022 онд малын индексжүүлсэн даатгалд 27456 өрхийн 5,7 сая толгой малыг 3,9 тэрбум төгрөгийн хураамжаар даатгуулсан. Улсын хэмжээнд нийт малчин өрхөөс даатгуулсан малчин өрх 14,4 хувьтай, даатгалд хамрагдсан малын тоо 8 хувийг эзэлж байна. 2022 оны даатгалын нөхөн олговор 2023 оны хагас жилийн мал, тэжээвэр амьтны тоо бодлогын дүнг үндэслэн олгогдоно гэсэн ийм мэдээллийг танилцуулж байна.

Н.Наранбаатар: Ганхүлэг сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хүрэлцэж ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Ганхүлэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Дэд сайд, Болорчулуун мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Наранчулуун мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийн зохицуулах хэтсийн дарга, Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мөнхбилэг малын индексжүүлсэн даатгалын ахлах мэргэжилтэн, Батболд Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга. Алга байна. Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл даатгалын хэлтсийн дарга. Одоо орж ирж байгаа байгаа юм байна. Батбаяр Бизнес хөгжлийн төслийн газрын дарга. Алга байна. Жавхланцогт Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн зөвлөх. Батцэцэг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын ахлах референт. Ийм хүмүүс байна.

Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Нэрсээ өгөөрэй. Өнөрболор гишүүнээр тасаллаа. Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Яах вэ энэ нөгөө Эдийн засгийн байнгын хороотой давхцуулчхаж. Тэгээд яг нөгөө даатгалын асуудал хариуцдаг Санхүүгийн зохицуулах хорооныхон тэнд асуудал нь орох гээд бас тэнд сууж байх шиг байна л даа. Манай Хөдөө аж ахуйн яамныхан маань ний нуугүй хэлэхэд яг малын индексжүүлсэн даатгалын асуудал Хөдөө аж ахуйн яам дээр хамааралгүй болчихсон юм. Сангийн яам энэ асуудлыг даатгал учраас аваад явчихсан. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороон дээр яг тэр бас.

Давхар даатгалын компанийн хүнээс бас хэд хэдэн асуудал байна. Ер нь яг индексжүүлсэн даатгал хэрэгжиж байх үед бол хэрэгжүүлэх төсөл хэрэгжиж байх үед бол нийт малын гэдэг нэг ийм заалт байсан маань одоо харсан чинь хууль батлагдахдаа тэгсэн юм уу, эсвэл хуульд өөрчлөлт орсон юм уу. Малын хорогдол дээр нь малын төрлөөр болчихсон юм байна. Нийт малын 6 хувь нь хорогдсон бол гэдэг байсан чинь нийт малын биш мал тус бүр дээрээ төрөл бүрээрээ 6 хувь гээд заагаад өгчихсөн. Энэ нь өөрөө бог дээр гэхэд бол 12 хувь болчихож байгаа юм л даа. Хонь нь 6 хувь, ямаа нь 6 хувь гээд хувиараа тооцохоор 12 хувь. Тэгээд энэ нь өөрөө боломжгүй ийм асуудал руу орчихсон. Тэгэхээр өнөөдөр малчид энэ даатгалд хамрагдах тухай ойлголтоосоо бүр маш дургүй болсон байна. Яагаад гэхээрээ ямар ч авах боломжгүй даатгалд малаа даатгуулаад тэр хүн зүгээр л ийм төлбөр төлж байгаа байхгүй юу. Татвар төлж байгаа юм шиг. Тэгээд энийг цаашид яаж авч явах юм. Манай Хөдөө аж ахуйн яамныхан энэ дээр бас жоохон шахаж өгмөөр байна. Яг малчдынхаа талаас. Өнөөдрийн Сүхбаатар аймаг, Хэнтий, Дорнодын

зарим сумууд гээд бараг 10 гаруй сум хамарсан гэнэтийн давагдашгүй хүчин зүйл боллоо шүү дээ байгалийн. Үүнээс илүү шуурга Монголд болохгүй байхгүй юу. Ийм шуурганд малаа алдчихаад даатгал авч чадахгүй үлдэх юм бол энэ даатгал хэрэггүй ээ. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань ямар бодолтой байдаг юм. Даатгалын компаниуд мэдээж давхар даатгалаа хийлгээд алдагдалгүй ажиллах боломж нөхцөлүүдээ өөрсдөө өөрсдийгөө даатгачихсан байгаа байх. Тэгэхээр энэ дээр даатгалын компанийн хүнээс асууя. Та бүхнээсээ асууя.

Тэгээд Хөдөө аж ахуйн яам бас Мал аж ахуйн газрын албан ёсны даргатай олон жил бас яаманд яг асуудлуудаа хариуцаж байсан даргатай болсонд бас баяр хүргэе Наранчулуундаа. Тэгэхээр Наранчулууны өмнө бол хэд хэдэн чухал асуудлууд байгаагийн нэг нь бол энэ шүү. Цаашилаад та бүхэн гамшиг зуд болохоор хот хүрэнээс мөнгө цуглуулдаа боль. Тэр чинь манай малчдын нэр хүндийг унагаад байна. Цалингийн 1 хувь ч гэнэ үү. Тэр мөнгө нь эргээд юундаа ч зарцуулагддаг юм мэдэхгүй шүү дээ. Харин тэр Онцгой комисс дээр гаргасан шийдвэрүүд чинь сайн болсон. Улсын онцгой комисс дээр хангалттай тэр шатахууны зардал, гэр тэр юмнуудыг нь олгосон. Тэр чинь болж байгаа байхгүй юу. Тэрийгээ нэгт нь сайн хийе. 2-т энэ нь даатгалынхаа асуудлыг маш сайн сайжруулмаар байна. 3 дахь асуудал бол мэдээж бүтээгдэхүүний малын түүхий эд, бүтээгдэхүүнийг үнэ цэнтэй л болго. Тэгэхгүй тэнд амьжиргаа залгуулдаг ядуу амьдралын тийм золиос болгомооргүй байна. Энэ хүмүүсээ мөнгөтэй болго. Өөрсдөө амьдралынхаа эрсдэлийг аваад явдаг ийм мал аж ахуйтай болохын төлөө та бүхэн маань бас зүтгээрэй. Наранчулуундаа бас дарга болсонд баяр хүргэе. Баярлалаа.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ. 1 номерын микрофон өгье.

М.Ганхүлэг: Ганибал гишүүний асуултад хариулъя. Яг саяын бас шуургатай үед орон нутагт бид бүхэн хамт ажиллаж таарсан. Тэр үед бас яг даатгалтай холбогдолтой асуудал дээр анхаараарай гэдэг энэ зөвлөгөөг өгч аж ажиллаж байсан. Түүний дагуу бид бүхэн хэд хэдэн удаагийн уулзалтуудыг зохион байгуулсан. Яг Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс даатгалын чиг үүргийг бас хариуцахгүй байгаа. Сангийн яаман дээр Санхүүгийн зохицуулах хороо үндсэндээ хариуцаад явж байгаа. Ямартай ч энэ чиглэлээр 7 сарын 1-ээр, 6 сарын 31-ээр бол үндсэндээ яг бүх тоо мэдээллүүд эцэслэгдээд бэлэн болно. Ингэхээр нөгөө хувьдаа хүрч байгаа байдлаар нь албан ёсны мэдээллүүд хийнэ. Цаашдаа Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр мал аж ахуйн сэргэлтийн чиглэлийн тусдаа бас хөтөлбөр боловсруулах, үндэсний хувьсгалтай адилхан хөтөлбөр боловсруулж ажиллахаар бид бүхэн бас ажиллаж байна. Энэ чиглэлд бол яг малын индексжүүлсэн даатгал болон бусад асуудлуудыг оруулж ирж байгаа. Яг таны хэлж байгаа малын таваарлаг байдлыг бий болгох, мал аж ахуй эрхлэгчдийгээ бас дэмжих чиглэлийн саналуудыг боловсруулаад Байнгын хороо болон бусад гишүүдээс саналуудаа авахаар бид бүхэн бас хүргүүлжээ гэсэн байдалтай ажиллаж байгаа.

Жишээ нь гэх юм бол бид богино хугацаанд энэ жилийн хувьд захиалгат ногоон тэжээлийн төслийг санаачлаад, нийтдээ 17 аймгийн 89 баг дээр зохион байгуулаад ажиллаж байна. Энэ хүрээнд бол нийтдээ 70 мянган га газрыг ногоон тэжээл тариалахаар тооцсон байгааг 30 мянгаар нэмэгдүүлэх боломж бүрдэж байгаа. Хөдөө аж ахуйг дэмжих сан дээрээс эдгээр 89 сумууддаа хөнгөлөлттэй улаан буудайн үр болон царгас, овьёосыг бас бид бүхэн олгохоор ажиллаж байгаа юм. Тэгээд энэ жил богино хугацаанд газар тариалан эрхлэгчид болон мал аж ахуйн эрхлэгч нарыгаа хооронд нь холбосон намрын цагт үндсэндээ үнэ өсөхгүй байх,

тэнцвэржүүлэх чиглэлээр бас арга хэмжээг авч ажиллахаар болж байгаа юм. Нийтдээ бол манай нийт 71,1 сая мал жилдээ өвөлжөөд ингээд бодоход бид бүхэн 30 хүрэхгүй хувьд нь л тэжээж байгаа. Тэгээд энэ хувь бол жилийн жилд өсөх ийм байдалтай байгаа. Бидний тооцоолж байгаагаар бол үүнийгээ бол 50-60 хувьд хүргэх хэмжээний тэжээлийн нөөцийг бэлдье гэсэн бодолтойгоор ажиллаж байгаа юм. Тэгээд энэ ажлыг сум, орон нутагт танилцуулах чиглэлээр бас нэлээдгүй бас ажиллаж байна. Ямар ч байсан энэ жилийн хувьд бол 100 мянган га талбайд ногоон тэжээл захиалгат байдлаар тариалах ийм хомсдол болон нийлүүлэлтийн эрсдэл үүсгэхгүй байхаар б ажиллаж байгаа юм гэдгийг бас хэлье. Яг малчдын бэлчээртэй холбогдолтой, уур амьсгалын өөрчлөлттэй холбогдолтой авч хэрэгжүүлж байгаа олон ажлуудаа нэгтгэсэн ийм нэгдсэн мал аж ахуйн сэргэлтийн хөтөлбөрийг боловсруулаад наадмын дараагаар бол бид бүхэн багууд дээр очиж мал эмнэлгийн үйлчилгээг таниулах, 100 жилийн ойн хүрээнд 100 сум дээр ийм өдөрлөг арга хэмжээ зохион байгуулах ажлыг бас хийхээр байгаа. Энэ үеэрээ газар дээрээс нь тодорхой судалгаануудыг аваад, намар нэгдсэн байдлаар олон нийтэд зарлахаар ийм ажлын хэсэг гараад, Фокус группийн судалгаа хийгээд бас ажиллаж байгаа гэдгийг бас хэлье ээ.

Н.Наранбаатар: Ганболд гишүүн асуулт асууя. Даатгалынхан ирсэн байна. 3 номерын микрофон дээр суучих. 3 номерын микрофон өгье.

Б.Жавхлант: Сайн байцгаана уу. Үндэсний давхар даатгал ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Ганибал гишүүний асуултад хариулъя.

Малын индексжүүлсэн даатгалын төсөл маань 2006 оноос Дэлхийн банкны

дэмжлэгтэйгээр Монгол Улсад хэрэгжээд, 2014 онд дууссан. Төслийн үр дүнд Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль батлагдаж гараад, үүний дагуу Хөдөө аж ахуйн давхар даатгалын компани нэртэйгээр манай компани 2014 оны 8 сард анх байгуулагдаж байсан. Өнөөдрийн байдлаар 100 хувь төрийн өмчит хувьцаат компани, хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр ажиллаж байгаа.

2006 оноос эхлээд Дэлхийн банкны мэргэжилтнүүд Монгол Улсад байгаа ган болон зудын эрсдэлийг үнэлээд, зудын эрсдэлээс малчин өрхийг хамгаалах даатгалын бүтээгдэхүүнийг судалгааны ажил хийгээд, энэ дээр нүүдлийн мал аж ахуйд тулгуурласан индексжүүлсэн даатгалын цоо шинэ тогтолцоог Монгол Улсад анх нэвтрүүлсэн.

Өнөөдрийн байдлаар яг нүүдлийн мал аж ахуйд тулгуурласан малыг индексжүүлсэн даатгалын тогтолцоо Дэлхийн хэмжээнд зөвхөн Монгол Улсад хэрэгжиж байгаа. Цорын ганц ийм систем байгаа. Эхний хувилбараараа гарсан тооцооллууд бол бүгдээрээ малыг 1974 оноос хойших малын хорогдлын статистик тоонд тулгуурлаад, актуард тооцоолол дээр үндэслэж байгаад малын хорогдлын хувь хэмжээг малын төрөл тус бүрээр нь тооцож гаргасан. Энэ даатгалын бүтээгдэхүүнийг анх танилцуулаад анх удаа Хэнтий, Баянхонгор, Увс гэсэн 3 аймгаас 2007 оноос эхлээд анх хийж хэрэгжүүлж эхэлсэн. 2009 оноос эхлээд 15 аймаг, 2010 оноос эхлээд 21 аймагт хэрэгжиж эхэлж байгаа ийм даатгалын бүтээгдэхүүн байгаа юм.

Энэ болохоор зэрэг үндсэндээ бол малчин өрхийн малын төрөл тус бүрээр нь даатгалынх нь үзүүлэлтийг тооцоод босго үзүүлэлтийг нь өнгөрч байгаа 60 гаран жилийн статистик тоонд тулгуурласан хэмжээгээр, ер нь тухайн малын төрөл тус бүр дээр 5-6 хувийн малын хоригдол бол хэвийн хэмжээний

хоригдолд тооцогдохоор байна гэсэн актуард тооцооллыг Дэлхийн банкны шинжээчид хийсэн байдаг юм. Энэ нь болохоор зэрэг малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд босго үзүүлэлт 6 хувь байна. Босго үзүүлэлт нь дээшээ, доошоо 1 хувь хэлбэлзэж болно. Үүнийг Засгийн газар тогтооно гээд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд тусгагдаад орчихсон. Үүнийг хийхдээ сумын хэмжээгээр төрөл тус бүрээр тогтооно гээд орчихсон байгаа.

Босго үзүүлэлтийн хэмжээ 5, 6, 4, 7 гэх янз бүрийн байдлаар хэлбэр нь тогтоогдож болно. Үүний тухайд юу гарах вэ гэхээр тухайн үедээ бол малчин өрхөд учрах даатгалын хураамжийн ачааллыг тооцоолоод босго үзүүлэлтийн хэмжээ хамгийн боломжит хувилбар нь 5-6 хувь байх юм байна. Түүнээс бага хэмжээнд байх юм бол малчин өрхийн төлөх хураамжийн хэмжээ өндөр болох юм байна. Түүнээс дээшээ болох юм бол малчин өрхдөө ашиггүй байх юм байна гэдэг ийм тооцооллыг хийгээд энэ 5-6 хувь гэдэг тоог анх гаргаад энэ хуулийн төсөлд тусгагдаад явчихсан ийм тогтолцоо байгаа юм.

Сүхбаатар, Хэнтий, саяын зүүн аймгуудад болсон байгалийн гамшигийн үзэгдлийн улмаас гарсан малын тоо толгойн хорогдлын хэмжээ бол эцсийн байдлаар гараагүй байгаа. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд зааснаар том малын хорогдлыг жилийн эцсийн мал тооллогын дүнгээс хагас жилийн мал тооллогын дүнгийн зөрөөгөөр тооцож олгох ийм хуулийн зохицуулалттай. Тэгэхээр хагас жилийн мал тооллогын дүн бол хараахан эцэслэгдэж гараагүй байгаа. Хагас жилийн мал тооллогын дүн гарсны дараа бол 2 аймагт олгогдох нөхөн төлбөрийн хэмжээ гарна. Өөрөөр хэлбэл.../минут дуусав/

Н.Наранбаатар: Ганибал гишүүн тодруулъя.

Н.Ганибал: Энэ жил яах вэ, зүгээр зүүн аймгууд, ер нь Монгол Улсын хэмжээнд энэ жилийн хувьд бол аймар хамгийн хүйтэн өвөл боллоо шүү дээ. -40, бараг зарим газраа -45 хүрсэн үү. Тэр бол нэлээн малын хорогдол үүссэн. 2-т хавар үнэхээр дулаарч өгөхгүй, тогтож өгөхгүй хавсарга салхитай нэлээн хорогдолтой. Дээрээс нь саяын зүгээр Сүхбаатар аймгийн хувьд. Тэгэхээр энэ болгон бүгдээрээ хамрагдана гэж ойлгож болох уу. Хагас жилийн малын тооллого гэдэг чинь энэ хорогдлууд бүгдээрээ тооцогдоно гэж ойлгож болох уу.

Н.Наранбаатар: 3 номерын микрофон.

Б.Жавхлант: Малын индексжүүлсэн даатгалын гол зорилго нь болохоор жилийн эцсийн мал тооллогоос хагас жилийн мал тооллого буюу 12 сарын сүүлээс 6 сарын сүүл хүртэлх хугацаан дахь том малын хорогдлын зөрүүгээр нөхөн төлбөр олгогдоно. Тэгэхээр энэ дунд болохоор зэрэг өвөл, хаврын том малын хорогдлын зөрүүгээр нөхөн төлбөр олгогдох ийм тогтолцоотой. Нийтдээ 2022 оны жилийн эцсийн байдлаар 27 мянган малчин өрх нийтдээ 3,9 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төлсөн байгаа. Улсын хэмжээнд. Энэ нь болохоор нийт малын 8 хувь, нийт малчин өрхийн 14 хувь байгаа.

Н.Наранбаатар: Ганболд гишүүн.

Г.Ганболд: Би энэ асуудлын орж ирж байгаа зорилго нь бол өвөлжилт хүндэрсэн, хавар зүүн аймгуудад нэлээн хүчтэй цасан шуурга болж мал нэлээн эрсдэлд орсон, энэнтэй холбоотой иргэдэд нөхөн төлбөр олгох хууль юу ч байдаггүй. Энэ асуудлыг л оруулж ирж байна гэж ойлгож байгаа юм. Тэгээд Хөдөө аж ахуйн яамныхан бол 7,9 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэлээ гээд. Энэ бол нөгөө Шадар сайдын нөгөө жоохон хөнгөлөлттэй өвс

тэжээлийн л юм байгаа. 8 тэрбум төгрөгийн эд зүйлийг дэмжлэг үзүүлээ гээд. Энэ бол Улаан загалмай л юм байгаа байх. Тэгээд эд нарыг түүгээд биччихсэн. Тэгээд сая баахан хохирсон айлуудыг яасан гэхээр материалыг нь бүрдүүлээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу шилжүүлээ л гэж байгаа байхгүй юу. Үгүй ээ тэнд юу байгаа юм. Юу ч байхгүй шүү дээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр юу байдаг юм. Ямар мөнгө байдаг юм. Тэр хохирсон иргэдэд өгөх ямар мөнгө байгаа юм. Тэгэхээр ийм юм оруулж ирээд, тэрний оронд та нар санал оруулж ирэх ёстой байхгүй юу. Гэнэтийн юман дээр чинь малын индексжүүлсэн даатгал чинь өөрөө тариф нь өндөр явахгүй байна. Нөхөн төлбөр бага байна. Одоо энд болзол хангахгүй ийм гэнэтийн, зуд, цас шуурганд 50-аас дээш хувиар малаа хорогдуулчихсан айлуудад яаж төрөөс нөхөн төлбөр олгодог ийм эрх зүйн механизмтай болох вэ гэдгийг л та нар санал оруулж ирэх ёстой юм байгаа шүү дээ Дэд сайд аа. Тийм юм байхгүй учраас өнөөдөр ингээд баахан шүүмжлүүлээд л таг. Нэг айл бүх малаа шуурганд хашаандаа, цасанд даруулчихсан, бүгдээрээ хорогдчихсон байна. Төрөөс юу ч өгч чадахгүй байгаа биз дээ. Өгөх боломж байхгүй байхгүй юу. Тэгээд энийг л гаргах гээд хэдүүлээ энэ асуудлыг оруулж ирээд байгаа юм шүү дээ. Гэтэл та нар энийгээ яриад, араас нь малын индексжүүлсэн даатгалтай хутгаад шал өөр 2 юмыг хольж оруулж ирээд, шийдвэрлэх юм юу ч байхгүй байна шүү дээ. Бид нар дээр Их Хурлаас, Байнгын хорооноос тогтоол гаргах ёстой байхгүй юу. Засгийн газар дээр энийгээ шийд ээ. Энэ даатгал чинь болохгүй байна. Тийм учраас ерөөсөө Их Хурлаас тогтоол гаргаад, хохирсон иргэдэд бид нар нөхөн төлбөр олгох журам ч юм уу юм оруулъя л гэдэг ийм л агуулгаар бид нар энэ асуудлыг оруулж ирсэн болохоос биш та нарын Улаан Загалмайгаас өгсөн тэр мөнгө төгрөг ерөөсөө хэнд ч хамаа байхгүй.

Тэгээд ер нь бол малын индексжүүлсэн даатгалыг бол би ойлгож байгаа. Тэгэхдээ энэ тогтолцоо нь аж ахуйн нэгжийн хэлбэр лүү ороод явсан байгаа байх гэж ойлгож байна. Яг ямар хэлбэртэй байна. 100 хувь төрийн өмчтэй байна уу. Тэгээд би нөхөн төлбөрийг нь харахад өнгөрсөн жил 3,6-гийн шимтгэл хураагаад 2,6-гийн нөхөн төлбөр олгоод, тэгээд 1 тэрбумын ашигтай ч юм шиг. Тэр нь яг журмаараа олгох ёстой нөхөн төлбөрүүдийг нь олгоод тийм юм гарчхаад байна уу. Эсвэл зарим нь үйл ажиллагааны зардалд явчхаад тэгээд тулгаад байгаа мөнгөө хуримтлал болгож авсан мөнгөнүүдээ тэрэнд нь тааруулж өгчхөөд байна уу гэдэг надад их сонин байна л даа. Зарим цас зудтай үед малын индексжүүлсэн даатгал чинь өөрөө асар том алдагдалд орох ёстой л байгууллага л даа. Бүгдийг нь өгч чадах юм бол. Тэгэхээр зэрэг бид нар ингэмээр байгаа байхгүй юу. Үүний хүрээг тэлэхийн тулд саяхан зарим гишүүд ноос арьс ширний урамшууллын мөнгийг Нийгмийн даатгалд нь тооцуулъя гэдэг хууль батлуулчихсан шүү дээ. Тэр биш. Харин малын индексжүүлсэн даатгалд тэр ноос, арьс ширний урамшуулаас бараг албан журмын болгоод айл өрхийг авч байж, энэ даатгал өөрөө цаашидаа амьд оршин тогтнож явах ёстой байхгүй юу. Малын индексжүүлсэн даатгалыг албан журмын болгочихмоор байгаа юм. Тэгээд бараг ноос, арьс ширний урамшуулаас нь тэрийг нь тооцоод авчихдаг. Тэгэх юм бол даатгалын чинь хураамж нь асар өндөр болно. Энэ хэмжээгээрээ бид нар журмаа жаахан бууруулаад нөгөө яриад байгаа малын хорогдлыг тэдэн хувь гэхгүйгээр үнэхээр бодитой хорогдсон байх юм бол өгдөг ийм тогтолцоо руу орж байж, энэ даатгал өөрөө үр дүнтэй болно. Тэгэхээр энэ даатгалын яг хураамжийг нөгөө хэдэн .../минут дуусав/

Н.Наранбаатар: Ганболд гишүүнд 1 минут нэмээд. Дараа нь больё. Тэгвэл

хариулт 3 номерын микрофон уу. 1 номерын микрофон эхлээд өгье.

М.Ганхүлэг: Ганболд гишүүний асуултад хариулъя. Тодорхой санал гаргаж ирсэнгүй гэдэг шүүмжлэлийг хүлээж авч байна аа гишүүн ээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Засгийн газрын тогтоолоороо бас энэ асуудлыг шийдвэрлэ. Малчдыг дэмжих хөтөлбөр, амьжиргааг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тодорхой арга хэмжээ ав гэдэг чиглэлийг Засгийн газрын хуралдаанд өгсний дагуу бид бүхэн бас хамтран ажиллаж байгаа. Яг манай Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс бол зөвхөн малын хорогдол, малын өвчин, үүнтэй холбогдолтой асуудлуудаас гадна ер нь мал аж ахуйн салбарыг ямар түвшинд аваачих вэ гэдэг нэлээн том хэмжээний ийм хөгжлийн хөтөлбөр бас боловсруулж Засгийн газрын хуралдаан болон Их Хуралд танилцуулахаар бид бүхэн бас ажиллаж байгаа. Тэгээд үүн дээр бол тодорхой хэд хэдэн ажлуудыг бид бүхэн бас хийсэн байгаа. Энд бол фокус группийн судалгааны ажлууд бол хийгдээд дууссан байгаа. Бүх бүсчлээд эрчимжсэн болон нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийг бүгдийг нь оролцуулсан нэлээн өргөн хүрээний ийм судалгааг бас хийсэн байгаа. Мөн мэргэжлийн талууд болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл, малчдын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдаад бид бүхэн бас эхний байдлаар үндэсний хөтөлбөр боловсруулаад ажиллаж байгаа. Энэ зуны хугацаанд эдгээр хөтөлбөрүүдээ бас яг газар дээр нь хэлэлцүүлэх энэ аяныг бас зохион байгуулахаар ажиллаж байгаа юм. Тэгээд бид бүхэн бас мэдээжийн хэрэг цаг хугацаа тулсан ажлууд бас байгаа учраас энэ хөтөлбөрөө бас нэлээн олон талын оролцоог хангасан байдлаар гаргая гэдэг дээрээ ач холбогдол өгч ажиллаж байгаа юм. Ирэх намар бас тодорхой түвшинд энэ хөтөлбөрөө Их Хурлаар оруулах хэмжээнд бэлдье гэсэн ийм байдалтай ажиллаж байгаа. Цаг хугацаа тулсан

иймэрхүү зүйлүүд бас байгааг бас ойлгож байна. Таны саналыг бас хүлээж авч байна.

Тэгээд бид хэд богино хугацаанд бол ямар ч байсан уур амьсгалын өөрчлөлттэй холбогдолтойгоор малчдаа жоохон бас мэдээлэлжүүлэе ээ. Одоо ер нь тэжээхгүйгээр бэлчээрийн болон тэжээлийн хосолсон байдлаар явахгүйгээр нөхцөл байдал цаашидаа бас нэлээн ийм хүндхэн байгааг бас ойлгуулъя гэсэн чиглэлээр ажиллаж байна. Дээрээс нь саяын миний ярьдаг 89 сум бол саналаа өгсөн байгаа энэ жилийн хувьд бол. Ирэх намар ногоон тэжээл бид бүхэн тэр тоо хэмжээгээр авна гэдэг захиалгаа өгсөн. Энэ захиалгынх нь дагуу бид нар яг бэлэн байгаа, тариалах боломжтой газар тариалан эрхлэгч нартайгаа холбогдоод хооронд нь холбож өгөх энэ үйлчилгээг бол энэ жил эхлүүлж байгаа юм. Ирэх жилээс Амарсайхан шадар сайдтай бид бүхэн хамтраад 100 сум дээр 50-100 га газруудыг сонгож олгоод, сумын Засаг даргын Тамгын газруудтай хамтарсан малчид өөрсдөө ногоон тэжээл тариалах боломжийг бүрдүүлэх тэр тоног төхөөрөмж, шатахуун, үрийн дэмжлэгүүдийг нь өгсөн энэ хөтөлбөрийг бас бид бүхэн зохион байгуулна.

Тэгэхээр яг энэ бэлчээрийн болон өвлийн хатуу цагийг бид бүхэн давахад тал талын оролцоог хангасан тодорхой ийм хөтөлбөртэй болъё, мөн дээрээс нь тусгайлсан ийм богино хэмжээний хөтөлбөрүүдийг туршиж зохион байгуулъя гэдэг ийм байдалтайгаар бид бүхэн ажиллаж байгаа юм гэдгийг бас нэмж хэлэе ээ.

Н.Наранбаатар: Нэмээд даатгалын талаар 3 номерын микрофон.

Б.Жавхлант: Ганболд гишүүний асуултад хариулъя. Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн орлогын хуваарилалтын талаар гишүүддээ товч мэдээлэл өгье. Малын

индексжүүлсэн даатгалын тухай хуулиар болохоор нийтдээ 4 түвшний эрсдэлийг гаргаж тавьсан байгаа.

1 дүгээрт нь болохоор малчны хүлээх эрсдэлийн түвшин буюу босго үзүүлэлт хуульд заасан 5-6 хувийн босго үзүүлэлт хүртэлх эрсдэлийг малчин өөрөө хариуцна. 6-аас дээш давсан хохирлын хариуцлагыг даатгалын компани, дотоодын давхар даатгалын компани, олон улсын давхар даатгалын компани, Засгийн газар гэсэн түвшинд эрсдэлийг ингэж хувааж ангилж оруулж ирж байгаа. Эрсдэлийн түвшин болгонд даатгалын хураамж маань хуваарилагдаад явж байгаа. Малчин өрхөд очиж байгаа үйлчилгээ хүргэх даатгалын компанийн зардлын түвшин бол 20-30 хувь дээр 100 хувиар тооцсон бол 20-30 хувь дээр борлуулалтын зардлын хэмжээ өртөг тооцогдож байгаа. 30-45 хувь нь болохоор хамтын эрсдэлийн сан гэж бий болгодог. Энэ болохоор цаашидаа хуримтлагдаад явдаг эрсдэлийн сан байгаа. Өөрөөр хэлбэл энэ жил өнгөрсөн жил гэхэд бага хэмжээний хохиролтой гарлаа гэхэд энэ жил илүү хэмжээний хохиролтой болохыг хамтын эрсдэлийн сангаасаа хуримтлагдсан сангаасаа нөхөн төлбөр олгодог тогтолцоо байгаа.

Түүний дараачийн түвшин болохоор хамтын эрсдэлийн сангаас дээшээ давсан хохирлыг үндэсний давхар даатгалын компани давхар даатгаж байгаа. Үндэсний давхар даатгалын компани дээр дунд түвшний эрсдэлийн сан гэж сан үүсэж байгаа. Энэ нь болохоор ойролцоогоор бас 20-30 хувийн хураамжийг сан болгож хуримтлуулж байгаа. 10-15 хувийг олон улсын давхар даатгалын компанид олон улсын давхар даатгалын хураамжийн зардал хэлбэрээр давхар даатгал төлдөг ийм хураамжийн тооцоололтой байгаа.

Н.Наранбаатар: Ганболд гишүүн нэмэлт 1 минут.

Г.Ганболд: Би уг нь шал өөр юм асуусан юм. Одоо байна шүү дээ хэ. Чиний ярьснаар жишээлэх юм бол өнгөрсөн жилийн би юм асуусан шүү дээ. 3,6-ийн билүү хураамжаас 2,6-гийн нөхөн олговор олгогчлоод байгаа шүү дээ тийм ээ. Тэр 2,6 нь ерөөсөө бүх мөнгийг нь яг хуульд заасны дагуу өгчхөөд байгаа мөнгө нь үү. Эсвэл одоо яг хуулийн дагуу хохирчлоод тэгээд төлбөрөө авч чадахгүй байгаа хүн байгаа юу. Танай хураамж хүрэхгүйгээс болоод. Байхгүй юу.

Н.Наранбаатар: Идэрбат гишүүн байхгүй байна. Дараа нь Өнөрболор гишүүн асуулт асууя.

Д.Өнөрболор: Даатгалын асуудал ер нь бүхий л салбарт даатгал ерөөсөө явахгүй байгаа тогтолцооны асуудал нь юутай холбоотой юм бэ гэдэг дээр та нар ер нь бас нэлээн шийдэл гаргах нь зүйтэй байх гэж бодож байна. Миний ойлгож байгаагаар Монгол улсад үндсэндээ автомашины даатгал л нэлээн сайн явж байх шиг байгаа юм. Тэгээд бусад өөр салбаруудад энэ даатгал ерөөсөө огт явагдахгүй байгаад байгаа байхгүй юу. Энэ юутай холбоотой юм бэ. Яг юунаас болоод ийм асуудал үүсээд байна. Тухайлах юм бол сая улсын хэмжээнд энэ ингэж байгаа юм. Малын индексжүүлсэн даатгал 2006 оноос хэрэгжиж эхэлсэн юм байна гэж би ойлголоо энэ танилцуулга дээрээс. Тэгээд 2014 он гэхэд үндсэндээ 21 аймагт тогтолцоо нь бүхэлдээ бүрэн хэрэгжихсэн юм байна гэж ойлгосон. Гэтэл улсын хэмжээнд нийт малчин өрхөөс даатгуулсан малчин өрх 14.4 хувь байгаа байхгүй юу. Нийт даатгалд хамрагдсан байж байгаа малын тоогоор аваад үзэх юм зөвхөн 8 хувийг эзэлж байна гэдэг бол маш хангалтгүй, маш чамлалтай бараг хэн хэнийхээ ажлыг барсан аягүй үр дүнгүй, бүтээмжгүй асуудал болжээ гэж харагдаж байна л даа миний хувьд. Тэгэхлээр яг энэ даатгалын асуудал чинь өөрөө цаашаа явахгүй байгаа асуудал нь яг юу юм бэ.

Энэ гишүүдийн хэлээд байгаа дээрээ та нар тодорхой шийдэл гаргаач. Гэтэл яг амьдрал дээр харахаар чинь даатгалын эрсдэлүүдэд нөхөн төлбөр олгогдох эрсдэлүүдийг аваад үзэх юм бол аягүй амьдралтай эрсдэлүүд байгаад байгаа байхгүй юу. Тухайлах юм бол зуд хаваржсааны хүндрэлээс үүсэх ч юм уу, эсвэл өвчин эмгэг, чоно, нохойд барцулах, хулгайд алдах ч гэдэг юм уу яг малчны хотхон дээр үүсдэг гол эрсдэлүүд байгаад байгаа байхгүй юу. Тэгсэн хэр нь амьдрал дээр энэ олон жилийн хугацаанд, 10 гаруй жил жилийн хугацаанд энэ тогтолцоо чинь өөрөө бүрэн нэвтэрч чадаагүй байна гэдэг чинь ойлгомжгүй байгаад байна. Тэгэхээр энэ дээр та нар өөрсдөө нэг тодорхой хэмжээний дүгнэлт, шийдэл гаргаж хууль, эрх зүйн хувьд эндээс ямар асуудлыг шийдвэрлэж байж ийм харилцан хаа хаанаа хэрэгцээтэй, үр өгөөжтэй тогтолцоог шийдвэрлэх вэ гэдэг тал дээр анхаарлаа хандуулах нь чухал асуудал байна гэж бол эндээс харагдаж байна. Тэгэхээр манай яамныхан ч гэсэн бодлогоор хангахдаа энэ асуудал дээр бол анхаарлаа хандуулаач гэж бол би бодож байна.

Нөгөө нэг асуудал нь бид нар энэ өвөлжилт, хаваржилт хүндэрсэн яг ний нуугүй. Тэгээд энэ танилцуулга дээр чинь нэлээн хэд хэдэн аймгууд орсон байна л даа. Гэхдээ манай Сэлэнгийн хувьд ч гэсэн бас үнэхээр асуудал үүссэн. Нэн ялангуяа өвчин эмгэгтэй холбоотой, нэн ялангуяа мялзан өвчнөөс болоод малчны хотхонд малчдад маш их гарз хохирол учирсан. Та бүгд мэдэж байгаа бол тэгээд би Хөдөө аж ахуйн яамнаас бас асуумаар байна л даа. Ер нь Сэлэнгэ аймагт нийтдээ 2023 онд айл өрх, малчдад хэр хэмжээний гарз хохирол учирсан бэ. Хэр хэмжээний нөхөн төлбөр олгогдсон бэ гэдэг асуудлыг та бүгд бас хариулж өгмөөр байна.

Дээрээс нь вакцинжуулах вакцин хангах тогтолцоо энэ асуудал чинь яг яадаг юм бэ. Малчид л бид нар руу асуудал ярихаараа үндсэндээ вакцин нь

ерөөсөө олдохгүй юм. Яаж тараалтаа хийгээд, түгээлтээ хийгээд, энийг урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ авдаг юм бэ энэ чинь өөрөө тийм бодитой амьдрал дээр бол хэрэгжихгүй байгаа нөхцөл байдал үүсээд байгаа юм биш үү. Энэ дээр та бүгд бас хариулт өгмөөр байна. Тэгээд манай Баруунбүрэн сумд нэн ялангуяа Сэлэнгэ аймгийн баруун бүс Орхонтуул, Баруунбүрэн сумд бараг нэг айл өрх 80, 90 малаа нэг дор устгуулах ийм гарз хохирол учирч байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь ийм хүнд эдийн засгийн нөхцөл байдалд ийм орлого ийм хомс ийм.../минут дуусав/

Н.Наранбаатар: Хариултаа эхлээд авчихъя. Эхлээд даатгалтай холбоотой асуудал байсан. Хэн хариулах вэ. 2 номерын микрофон өгье.

Ж.Нарантуяа: Мал эмнэлгийн ерөнхий газраас Өнөрболор гишүүний асуусан асуултад хариулъя. Ерөнхийдөө нийтэд нь танилцуулахад одоо өнөөдөр бол Монгол Улс бол шүлхий өвчнөөр тайван байна. Яг гоц халдварт өвчин бол саяын асуусан бог малын мялзан өвчин, хонины цэцэг өвчний тохиолдол бүртгэгдчихсэн. Үүн дотроо бол Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Баруунбүрэн сумд бол сая халдвар Булган аймгаас гаралтайгаар тэнд бол халдварын тохиолдол илэрсэн. Тэгээд бид нар бол маш хурдан арга хэмжээ авч голомтын бүсийг бол хумьсан. Одоогоор бол хязгаарлалтын дэглэмд шилжчихсэн байна. Тэгээд ер нь бол дархлаажуулалт, вакцинжуулалт гээд хуулиар бол яах вэ дархлаажуулалт гэж ярьж байгаа юм. Бид нар энгийн үгээр бол вакцинжуулалт яаж явдаг юм бэ гэхээр хуульд бол төрөөс дааж байгаа, орон нутгаас дааж байгаа 3 ангиллаар дархлаажуулалтын ажил явагдаж байгаа. Тэгээд гоц халдварт өвчнийг бол улсаас вакцинжуулах, үйлчилгээний хөлс, ер нь бүх зардлыг бол хариуцаж явдаг. Тэгээд тэр малчдын асууж байгаа асуудал бол яагаад тэгж асуудаг гэхээр нөгөө хязгаарлалтын дэглэмийг хумих

зорилгоор яг хязгаарлагдмалд ийм бага вакцин 20 сая тун вакцин бид нар хангагдсан. Тэгээд энэ вакциныг хүртээх яг нөгөө стратегийн судалгаа хийгээд дархлаажуулах газрыг голомт өвчин үүссэн тохиолдолтой нь холбоод, шинжлэх ухааны үндэстэй хумих гээд явж байхад тэр өвчнийг сураг дуулсан улсууд дамаар ч юм уу худалдан авах эсвэл бие биедээ буруу мэдээлэл өгснөөс болж ийм мэдээллийн зөрүүтэй асуудал гараад байгаа.

Тэгээд яг үнэндээ өнөөдөр бол бог малын мялзан өвчний дархлаажуулалтын ажил бол 5 сарын 29-өөс эхэлсэн. Өнөөдрийн байдлаар бол 32 хувийн дархлаажуулалттай. Шүлхий өвчний дархлаажуулалт бол 87 хувийн гүйцэтгэлтэйгээр явж байна. Тэгээд энэ жил бол 20 сая тун вакцины асуудал бол ямар ч байсан яг энэ галыг л унтраах зориулалттай байгаа. Тэгээд цаашид бол яамны зүгээс бид нарын зүгээс санал оруулж байна. Яагаад гэхээр хэдийгээр нөгөө хүнсний аюулгүй байдал 36 дугаар тогтоолтой холбоотойгоор мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тодорхой хэмжээний мөнгө тавьсан ч гэсэн энэ 70 сая малын асуудлыг бол хүртээлтэй биш учраас 20 сая боломжит жсоохон энэ нөөцөөрөө ямар ч байсан зөв тактикаар арга хэмжээ аваад хэрэгжүүлж ажиллаж байна. Тэгээд бид нарын жилийн сонгосон тактикийн асуудал та бүхэнд бас мэдээлэлд хүрсэн байх. Яагаад гэхээр хонийг нь үлдээгээд төл ямаагаа вакцинжуулж байгаа. Энэ нь яагаад гэхээр нөгөө малынх нь насжилттай холбоотой. Тэгээд энэ өвчнийг бол дэлхийн 2030 он гэхэд устгана. Тэгээд үүнтэй холбоотойгоор бид нар малын насжилттай холбоотой ийм стратегийн арга хэмжээ аваад явж байна. Сэлэнгэ аймаг бол өнөөдөр Мал эмнэлгийн газар бол маш сайн ажилласан. Орхон, Баруунбүрэн сум бол намжмал байдалд орчихсон байгаа.

Н.Наранбаатар: 3 номер даатгалын асуудлаар хариулт өгнө.

Б.Жавхлант: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Яг үнэхээр бол манай даатгалын салбарын хөгжил хөгжиж байгаа орнуудынхаа түвшинээс бол 3 дахин доогуур байгаа. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин бол яг хөгжиж байгаа орны түвшинээс 3 дахин, нөгөө хөгжингүй орон онуудаасаа 10 дахин бага түвшинд байгаа. Хамгийн их нэвтрэлт сайтай байгаа нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тогтолцоо явж байгаа. Энэ бол 2011 онд анх нөгөө жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хуульд хэрэгжсэнээрээ энэ бол нэлээн даатгалын салбарт байгаа том соёл, том эргэлтийг авчирсан ийм шинэчлэл болсон. 2014 онд Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль хэлэлцэгдэж байх явцад 2 төрлийн асуудлыг ярьсан. Тэр нь болохоор сайн дурын даатгал дээр ер нь байх уу, албан журмын даатгалаар байх уу гэдэг асуудал хэлэлцэгдэж байгаад сайн дурын үндсэн дээр малыг даатгалд хамруулах тогтолцоо нь хэрэгжиж эхэлсэн юм. Ер нь хамрагдалт муу байж байгаагүй үндсэн гол шалтгаан бол хэд хэдэн шалтгаанууд байгаа гэж харж байгаа.

1 дүгээрт нь яах вэ, манайх нүүдлийн мал аж ахуйд суурилсан тархай бутархай байршилтай гэдэг утгаараа тухайн малчинд хүрэх санхүүгийн үйлчилгээний хүртээмжээс шалтгаалж байгаа. Үүнийг шийдэх арга замыг хайж байгаад сүүлд нь банкнуудыг даатгалын борлуулалт хийх суваг болгож ашиглаж байгаа. Өөрөөр хэлбэл малчны зээл авах гэж байгаа хүн маань очоод хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар болох юм бол малаа даатгуулж байгаа тогтолцоо маань одоогийн өнөөдрийн байдлаар бол дийлэнх борлуулалтыг хийж байна. Өөрөөр хэлбэл малчин малаа даатгуулах юм бол хүүгийн хөнгөлөлт аваад даатгал болон банкны зээл авах боломжийг бүрдүүлж байгаа.

Даатгалын төлөөлөгч буюу уламжлалт сувгийг ашиглаад явахаар үндсэндээ бол даатгалын зардал асар өндөр гараад эхэлж байгаа. Ийм хүндрэл байгаа.

Түүний дараа нь юу вэ гэхээр хөшүүргийн тогтолцоог бас бий болгох шаардлагатай юм байна гэж харж байгаа. Түрүүний Ганболд гишүүний дурдсанчлан ноос, ноолуурын урамшуулал болоод бусад төрлийн урамшуулал, хөтөлбөрүүдэд хамрагдахад малын индексжүүлсэн даатгалын тодорхой хөшүүргийг хийж өгөх юм бол бас энэ хамрагдалтыг нэмэгдүүлэх боломж бололцоо бүрдэнэ гэж харж байгаа.

Мөн түүнчлэн хагас жилийн мал тооллого гэдэг ийм тооллогын асуудал байгаа. Энэ бол үндсэндээ бол малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр тооцоолоход гаргаж ашиглахаар шийдэл гаргасан. Энэ хагас жилийн мал тооллогыг бол хуульд тусгагдаж оруулсан байгаа. Тэгээд хагас жилийн мал тооллого бол харамсалтай нь нийт малчин өрхийнхөө 16 хувьд ч тооллого хийгдэж байгаа. Энэ нь болохоор заримдаа бас статистик тоон мэдээллийн хувьд бас бүрэн дүүрэн бодитой тоон мэдээлэл дээр хүрч чадахгүй байх ийм эрсдэл дээр тулгардаг. Ийм болохоор хагас жилийн мал тооллогын үр дүнтэй болох асуудал дээр бас анхаарлаа хандуулна. Нөхөн төлбөрийн хүртээмж илүү нэмэгдэх боломжтой.

Ер нь цаашилаад малыг бүртгэлжүүлээд эхлэх юм бол ер нь мал тооллогын асуудал бол 2 дахь ээлжийн асуудал болох юм байна гэж бид нар харж байгаа. Өөрөөр хэлбэл малыг бүртгэлжүүлсэн тохиолдолд малын хорогдлын хэмжээ, зүй бус хорогдлын хэмжээ шууд гарна. Манай систем болохоор малын зүй бус хорогдлын тоо гарсан тохиолдолд малчин өрх тус бүрд Хаан банкны дансаар дамжуулаад нөхөн төлбөрийг шууд олгодог систем бол бүрэн бий болчихсон байгаа.

Н.Наранбаатар: Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Тэгэхээр сая тэр манай Сэлэнгийн баруун бүсүүд гээд байсан шүү дээ. Баруунбүрэн, Орхонтуул сумуудад бас малчид маш их олноороо мал у устгуулж байгаа учраас их том гарз хохирол учирч байгаа байхгүй юу. Тэгээд малчдад бол маш хүнд тусаж байна л даа. Тэгээд үүнтэй холбоотойгоор ямар нэгэн нөхөн төлбөрийн асуудал байдаг юм уу. Энэ тал дээр та нар бас мэдээлэл өгмөөр байна гэдэг асуудлыг бас асууя.

Нөгөөтээгүүр энэ даатгалтай холбоотой асуудал байна шүү дээ. Энэ сайн дурын даатгал сая юу гэсэн албан журмын даатгал гээд энэ эрх зүйн орчныг нь бүрдүүлэх асуудлын нэг хэсэг юм болов уу гэж би бас ингэж ойлгож байна л даа. Тэгэхээр яаж байна гэхээр ер нь бусад өөр улс орнуудад бол даатгал, нэн ялангуяа хүнсний аюулгүй байдал, хангамжтай холбоотой асуудал байгаа учраас бусад өөр улс орнуудад тухайлах юм даатгалын компаниуд төрийн байгууллагуудтай маш уялдаа холбоотой ажиллаж байж өнөөдөр.../минут дуусав/

Н.Наранбаатар: Өнөрболор гишүүнд 1 минут.

Д.Өнөрболор: Тэгэхээр би даатгалын компаниудыг хоорондоо уялдаа холбоотой шийдэл гаргаж ирж, төртэй уялдаа холбоогоо хангаж ажиллах нь маш чухал гэж үзээд байгаа юм аа. Яагаад тэгж байна гэхээр хүнсний хангамж, аюулгүй байдал гэдэг чинь бол улс орны болоод иргэн бүрийн эрүүл байх чухал асуудал шүү дээ. Тэгэхэд төр даатгалын компани 2 хоорондоо бусад өөр улс орнууд уялдаа холбоотой хамтарч ажилласнаар энэ эрсдэлийг алга болгож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тогтолцоог, энэ хамрагдалтыг бүрэн бий болгох, махан

дээр ч бий болж болж байна. Хүнс, ногоо дээр ч бий болж болж байна. Ер нь даатгалын компаниуд улс орныхоо нэн ялангуяа хянан шалгах, эсвэл эрсдэлгүй, аюулгүй байх тал дээр даатгалын компаниудын үүрэг оролцоо маш өндөр байдаг шүү дээ. Тэгээд яг энэ талаасаа та бүгд маань бас шийдлийг гаргаад, төртэй хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх.../минут дуусав/

Н.Наранбаатар: Санал уу, асуулт уу. Нөгөө нөхөн төлбөртэй холбоотой. Хэн хариулах вэ. Хэдэн номер вэ. 3 номер, дараа нь 1 номер. 2 номерт өгчих.

Ж.Нарантуяа: Саяын нөхөн олговрын асуудал. Саяын баруун бүрэн Орхонтуулд гарсан тохиолдол ер нь Монголд халдварт өвчин гарч байгаа тохиолдол бол эрүүл мэндийн хуульдаа бол 12 цагийн дотор малчин мал эмнэлэгтээ, малын эмчдээ мэдээлэх ёстой байдаг. Ихэнх тохиолдолд өөрсдөө хариуцлага алдаж, мэдээлээгүй байгаа учраас бид нар бол өөрсдийнх нь буруутай үйл ажиллагаанаас болж байгаа гэсэн учраас нөхөн олговор олгохгүйгээр устгуулах, өөрсдийнх нь гарын үсэгтэйгээр зөвшөөрөөд, өөрийнх нь буруу гэдгийг нь ойлгуулаад устгал явж байгаа. Хэрвээ 12 цагийн дотор мал эмнэлэгтээ мэдээлээд, яг хуулийн дагуу өөрсдөө эрсдэлээ хамгаалж чадах юм бол 90 хувийн нөхөн олговортой өвчин бог малын мялзан. Тэгээд үүний цаана бол бог малын мялзан өвчин, энийг ингэж мал эмнэлгийн арга хэмжээг ингэж ойлгуулж сурталчлахгүй бол яг эцсийн эцэст.../минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмэлт 1 номер.

М.Ганхүлэг: Өнөрболор гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Саяын мэдээллийг бол бас малчид маань нэлээн сайн авах хэрэгтэй юм байгаа юм. Гоц халдварт өвчнөөр тухайн мал хэрвээ өвчилсөн тохиолдолд 12 цагийн дотор мэдэгдээд, тэрийгээ бас цаашаа халдварлахаас сэргийлсэн ийм хариу арга

хэмжээг бол үндсэндээ авдаг байгаа. Тэгэхээр 12 цагийн дотор үндсэндээ манай мал эмнэлгийнхэн маань очиж шинжилгээ юмнуудыг нь гаргаад, үндсэндээ нөхөн олговор 90 хувь хүртэлхийг улсын төсвөөс олгох ийм бас зохицуулалтууд байгаа. Цаашидаа яг энэ мал эмнэлгийн асуудалтай холбогдолтойгоор бас бид бүхэн хэд хэдэн саналуудыг бас санаачлаад явж байгаа. 1 бог болон бод малыг вакцин тарилга үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр саналуудыг гаргаад Сангийн яаманд хүргүүлсэн байгаа. Одоогоор бол бог мал 250, бод мал бол 400 төгрөг байгаа бол энийг 1000-1500 болгох.../минут дуусав/

Н.Наранбаатар: Би бас 2 асуулт. Өнгөрсөн 7 хоногт говийн бүс нутгуудаар Дорноговь, Өмнөговь аймгийн нутгуудаар бас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай ажилласан. Зуншлагын байдал бол үнэхээр хүнд, нүд халтирам байна. Замд явж байхад бол замын хажууд унагатай гүү, унага нь зогсоогоороо эх нь харангадаад хэвтчихсэн. Тэгээд бидэнтэй хамт явж байсан залуучууд нэг касканд ус хийж өгөөд босгоод л орхисон гэх мэтчилэн. Тэгээд ногоо байхгүй. Говийн бүс нутгийн нийт газар нутгийн 2 хувьд нь ногоо цухуйсан, бусад нь гантай ийм байдалтай. Отор нүүдэл маш ихтэй байна. Отор нүүдлээ дагаад халдварт өвчин гарах магадлал их өндөр болчихлоо. Ялангуяа мялзан өвчний голомттой аймаг, сумуудын нутгуудаар тараад явцаагчигсан, холилчихсон, ерөөсөө хяналт байхгүй, зах замбараа байхгүй л ийм байдалтай л болсон байна шүү. Тийм учраас энэ дээр цаашидаа анхаар. Вакциныхаа хүрэлцээ хангамж, нөөц дээрээ цаашидаа анхаарч ажиллахгүй бол болохгүй байна. Малын хорогдол их байна. Малынхаа хорогдол, сэг зэмээ дагаад халдварт өвчин бас дахиад гарах эрсдэл маш их өндөр байна. Энэ дээр та бүхэн ямар зүйлүүдийг хийхээр төлөвлөж байна. Нөөц ямар байна вэ. Энэ говийн бүс нутгийн сүрхий

отор нүүдэл, сэг зэм, өвчний байдал энийг та бүхэн мэдээлэл хэр байгаа вэ гэсэн эхний асуулт байна.

Дараа нь энэтэй холбоотойгоор боловсон хүчний асуудал. Ургамал, хорио цээрийн байцаагчийн орон тоо байхгүй байгаа. Өмнөговьд л гэхэд. Мөн хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтын байцаагчийн орон тоо дутуу. Нэг бол орон тоог нь нэмэх боломж хэр байдаг юм. Аль эс үгүй бол одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд ийм байцаагчийн эрх өгөх ийм боломж байна уу, үгүй юу. Энэ дээр та бүхэн хэрхэн анхаарч байна.

Ялангуяа уул уурхай, бүс нутаг хүн ам олноороо суурьшсан аялал жуулчлал их хөгжиж байгаа олон кемпүүд байгаа газруудаар үнэхээр хүрэлцээ муу байгаа. Энэ дээр та бүхэн хийж байгаа ажил юу байна. Ер нь боловсон хүчний дутагдал улсын хэмжээгээр ямар байгаа юм. Энэ дээр юу хийхээр төлөвлөж байгаа юм гэдэг асуудал дээр бас хариулт авъя. Тэгээд ер нь бол мал аж ахуйн бодлого зохицуулалтаа цаашидаа бид анхаарахгүй бол малын тоо толгой ер нь хязгааргүй болчихлоо. Замбараагүй, хязгааргүй өсөж байна. Ер нь уул уурхайгаасаа илүү цөлжилтийг чинь мал аж ахуйн салбар өөрөө бий болгоод байгаа л ийм л дүр зураг харагдаж байгаа шүү дээ. Зарим газар бол уул уурхайтай сумд зуншлага сайн, ногоотой, бороотой байхад огт уул уурхай байхгүй газар хэдэн жил гандсан цөлжсөн ийм байдалтай харагдаж байгаа учраас малынхаа цаашидаа тоо толгойн дээрээ хэрхэн анхаарах юм. Энэ дээрээ зарим төрөл дээр нь хязгаарлалт тогтоох ийм бодлого байна уу, үгүй юу гээд ийм зүйлүүд дээр та бүхэн нэг мэдээлэл өгөөдөх өө.

1 номер.

М.Ганхүлэг: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Бид бүхэн яг энэ мал аж ахуйн вакцинжуулалттай холбогдолтой асуудал дээр бас

баримталж байгаа яг тодорхой хэмжээнд тэр тарифыг өсгөх энэ чиглэлийн ажлууд бас явагдаж байгаа. Мөн дээрээс нь цаашидаа халдвар хамгаалалт гарахгүй байх чиглэлийн хүрээнд бас олон улсын байгууллагуудтай бид бүхэн хамтраад зөвлөсний дагуу яг өндөр эрсдэлтэй байгаа аймгууддаа бол бог малын төл болон ямаагаа тарих ийм арга хэмжээнүүдийг бол аваад, бог малын бусад яг дунд эрсдэлтэй байгаа дээр нь бол яг төлөө тарих арга хэмжээнүүдийг аваад ажиллаж байна.

Бусад Дорнод, Сүхбаатар болон баруун аймгууд дээр бол эрүүл ийм бүсүүд байгаа. Ийшээ алдахгүйн тулд бог малын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах тогтоолын төслийг бас Засгийн газарт бид бүхэн өгч ажиллах, цаашидаа отортой холбогдолтой үүн дээр зохицуулалтууд гаргах энэ ажлууд бас хийгдээд явж байна гэдэг мэдээллийг өгөхөөр байна.

Малын сэг зэм устгалын ажил бол одоо 79 хувьтай байгаа. Өөрсдийн боломжийнхоо хэмжээндээ бол манай Мал эмнэлгийнхэн болон Хөдөө аж ахуйн тасгийнхан бас ажиллаад явж байна. Энд тодорхой шатахууны болон халдвар хамгааллын бодисын дэмжлэгүүдийг бид бүхэн удаа дараа бас газрууддаа өгөөд, хариу арга хэмжээнүүд бас аваад явж байна.

Боловсон хүчний юу асуудал дээр бол сая бид бүхэн бас хялбаршуулсан журмаар 74 улсын байцаагчийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран шалгалтад оруулсан. Үндсэндээ эдгээр байцаагч нар маань бол бас ажилдаа ороход бэлэн болоод шаардлагаа хангаад, шалгалтуудаа өгөөд орсон байгаа. Цаашидаа ер нь боловсон хүчний асуудлыг тусад нь салгаж нарийн бодлого болгож гаргах зайлшгүй шаардлагатай. Манай дээр бол Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн газрууд дээр бол ер нь бол орон тоо яг нөхцөл байдал дээрээ дандаа дутуу. Зарим газар бүр байхгүй ийм байдалтай бас байгаад

байгаа. Сая ковидын тухай хуулиас үүдээд нэлээдгүй олон ажлын байрууд эзгүй болох ийм асуудлууд гарсан. Тэгээд яг сум орон нутаг дээр төрийн албаны шалгалт өгсөн, дээрээс нь дээд боловсролтой, нарийн мэргэжлийн ийм хүмүүс бас очиж ажиллах нөхцөл байдал бас бүрдэхгүй байгаа асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр тусдаа бас зохион байгуулал хийх, хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд арай бас өөр шалгуураар зохион байгуулах гэдэг шийдлүүдийг бас гаргаж ирэх зайлшгүй шаардлагатай болсон. Нэг талдаа бол ажиллах боломжтой хүмүүс байгаа. Тэгэхдээ яг нарийн шаардлагуудыг хангаж чадахгүй байгаа ийм асуудлууд бас байгаа юм. Тэгээд энэ дээр бид бүхэн судалгаанууд хийгээд, тодорхой бүсчлээд нарийн шалгалтад бэлдэх сургалтуудыг нэг бүрчлэн зохион байгуулаад, нэлээн 70-аар нь, 50-аар нь шалгалтуудад оруулаад ажлын байраа нөхөх ийм арга хэмжээнүүдийг аваад бас ажиллаж байна.

Н.Наранбаатар: Нэмэлт хариулт байна уу. Дууссан уу. Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Яамны танилцуулгатай бол танилцсан. Ирсэн мэдээлэлтэй бол танилцсан. Ер нь яах вэ орон нутгаар ажиллаж байхад малчдын хувьд маш хүнд үеийг л туулж байна. Махны үнийн асуудал, түүхий эдийн үнийн асуудал би бол танай яаманд байнга л энэ асуудлуудыг ярьж байдаг хүмүүс. Дөнгөж сая бол бас бэлчээрийн зохицуулалтыг бас хууль өргөн бариад явж байна. Энэ хавар малчид олон түмэнтэй уулзаад явж байхад нэг асуудал яригдаад байгаа нь хаврын хүндийг бол та бүхэн бол мэдэж байгаа. Энэ хүндийг даваад туусны ар дээр бид даатгуулсан даатгалынхаа үр шимийг хэзээ үзэх вэ гэдэг ийм асуултууд маш ихээр тавигдсан. Ялангуяа 4 сар, 5 сарын эхээр, дундуур болсон тэр байгалийн гамшигт аюулт үзэгдлийн үеэр би Баянхутаг сумд бас ажиллаж ингэж

таарсан. Тэгээд Бат-Эрдэнэ аварга бидний хувьд бол та бүхэн рүү бичиг явуулсан. Бичиг бол ямар ч хариу байхгүй ийм байдалтай байгаа. Үүний өмнөх Байнгын хороо дээр та бүхнээс тодруулсан, хариулт бол маш бүрхэг, бөөрөнхий ийм л зүйл байна лээ. Тийм учраас ер нь Хөдөө аж ахуйн яам, мал, малчны асуудал дээр ер нь ямархуу байр суурьтай байдаг юм бэ. Энэ суудал руу яаж анхаарлаа хандуулдаг юм. Ер нь ямархуу зүйл яваад байдаг юм бэ. Малчид иргэд болохоор машинаа мөргөлдүүлээд шууд даатгал авдаг. Тэр шиг миний 2, 3 үхэр үхлээ. 10 үхэр нь үхсэн байна, хорогдсон байна, би даатгалаа яах вэ гээд. Тэгээд энийгээ хэнд хэлэхээ мэддэггүй. Энийг зүгээр л нэг шагнал авахад байдаг материалын нэг хэсэг юм шиг, эсвэл тэгээд нөгөө улсын аварга янз бүрийн аваргууд болоход бүрдүүлдэг материалын нэг хэсэг ч юм шиг, зээл авахад заавал арилжааны банкнууд даатгал нэхээд байдаг, тэгээд л хүссэн ч хүсээгүй даатгуулаад л тэгээд л явдаг. Тэгээд эргээд ямар ч хариу байдаггүй гэсэн ийм зүйлүүдийг хэлээд байгаа юм. Тэгээд би эндээс нэг тодорхой 2, 3 асуулт асууя гэж бодоод байна. Ер нь малын индексжүүлсэн даатгал Монгол улсад эхлээд 2014 онд малын индексжүүлсэн даатгалын хууль батлагдсан юм билээ. Малын хорогдлыг ер нь тухайн үед ажиллаж байсан хүмүүс энэ дотор байгаа байх. Малын хорогдлыг сумаараа ер нь 6 хувь гэдгийг ер нь яг ямар үндэслэлээр гаргасан юм бэ. 6 хувь. Үүнээсээ гадна яг өгдөг дээрээ 6 дотроо дахиад төрөл бүрээрээ 6 гэдэг ийм шалгуур тавиад байна. Тэгээд яг ямар учиртай ийм шалгуур тавиад байгаа юм бэ. Энэ дээр надад нэг тодорхой хариулж өгөөч. 2014 оноос үндэсний давхар даатгал гэдэг компани гээд, ХК. Энэ нь яг өмчлөлийн хувьд яг ямар компани байдаг юм бэ. Даатгалын тогтолцоог би бол нэлээн сайн хөгжүүлэх үүднээс хийсэн байх гэж ингэж бодож байгаа. Тэр үйлчилгээний төрлүүдийг нь харахад бол Хөдөө аж ахуйн салбар дээр маш их байдаг юм

байна лээ. Яг энэ дээр малын индексжүүлсэн даатгалын асуудал дээр та бүхэн бас энэ компанийн түүх, тэр хувьцаа байдаг юм уу, юу байдаг юм. Тэр нь яг ямархуу юм байдаг юм. Ингээд энэ он болгоны дарааллаар 2020 оноос аваад үзэхээр овоо гайгүй өсөж явж байгаад, 2022 онд хамгийн сүүлийн 3 жилийн хугацаанд 27,4 мянган өрх даатгуулсан байна шүү дээ. 2021 онд 34 мянган өрх даатгуулаад 3,9 тэрбум төгрөгийн хураамж даатгуулчхаад байхад эргээд 125 малчин өрхөд 5,8 сая төгрөг олгогдсон юм байна шүү дээ. Тэгэхээр чинь энэ чинь нөгөө малчдын хэлээд байдаг миний даатгал хаашаа ороод байгаа юм бэ. Яагаад минийх ирэхгүй байгаа юм бэ гээд. Тэгээд энийг нь судлаад үзэхээр ердөө л 6 хувийн босго гэж тавиад л, босго нь цаашаагаа дахиж салбарлаад л тухайн сум дээр төрөл болгоноороо ямаа бол 6 хувь байх ёстой. Дээшээ байх ёстой гээд заагаад өгчихсөн. Эндээ хүрэхгүй бол олгодоггүй гээд. Тэгэхээр энэ тал дээр би нэлээн сайн тодруулга та бүхнээс авъя гэж ингэж бодож байна.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ. 3 номерын микрофон.

Б.Жавхлант: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

1 дүгээрт нь эхлээд компанийнхаа талаар товч танилцуулгаа хийе. Үндэсний давхар Даатгал компанийн гүйцэтгэх захирал Жавхлант. Үндэсний давхар даатгал компани маань 2014 онд Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль дээр үндэслэгдэн байгуулагдсан. Анх байгуулахдаа “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нэртэйгээр Засгийн газрын 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан. Ийм төрийн өмчит аж ахуйн нэгж байгаа. Анх байгуулагдахдаа Хөдөө аж ахуйн чиглэлээр буюу малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх дагнасан үйлчилгээ эрхлэхээр байгуулагдсан. 2019 оноос эхлээд

үндэсний хэмжээнд ердийн давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаагаа өргөжүүлж Засгийн газрын тогтоолоор үйл ажиллагаа өргөжүүлж явж байгаа ийм Төрийн өмчит хувьцаат компани байгаа. Өнөөдрийн байдлаар төрийн өмчийн төлөөллийг Сангийн яам хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

6 хувь гэдэг босго үзүүлэлт бол Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд тусгагдсан босго үзүүлэлт гэсэн ийм үзүүлэлт байгаа. 2006 онд Дэлхийн банк Монгол Улсад малын индексжүүлсэн даатгалын тухай төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Ингэж хийж эхлэхдээ Монгол Улсад хамгийн тохиромжтой малчдын санхүүгийн боломжид нийцсэн мөн түүнчлэн гамшигийн эрсдэлээс хамгаалах зорилготой ийм гамшигийн эрсдэлийн даатгалыг боловсруулах олон улсын шинжээчид ажиллаад, Монгол Улсад харьцангуй малын хорогдлын статистик тоо сайн байдаг. Ялангуяа 1974 оноос хойших юуны статистик тоон мэдээлэлд тулгуурлаж байгаад 5-6 хувь гэдэг малын хорогдлын тоо хэмжээг гаргаж ирсэн. Актуарын тооцоолол гэж ярьдаг. Математик тооцоолол дээр ерөнхийдөө тухайн жил болгон 5-6 хувийн малын хорогдол бол хэвийн хорогдолд тооцогддог юм байна гэдгийг олон улсын шинжээчид тогтоогоод, 5-6 хувийн үзүүлэлтийг босго үзүүлэлт гэдэг юмаар тогтоож анх төсөл хэлбэрээр 2007 оноос эхлээд Увс, Баянхонгор, Хэнтий аймгууд хэрэгжүүлж эхэлсэн. Ингэж хэрэгжүүлж эхлэхдээ малын төрөл тус бүрээр, сум тус бүрд 5-6 хувийн босго үзүүлэлтийг тогтоогоод, 2007 оноос 3 аймагт, 2010 оноос эхлээд 21 аймагт хэрэгжүүлж эхлээд 2014 оноос эхлээд төр-хувийн хэвшлийн хамтарсан түншлэлээр энэ үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа. 5-6 хувь бол түрүүн хэлсэн хэвийн хорогдлын хэмжээ байдаг юм байна. Төрөл тус бүрээр нь тооцдог юм байна. Энийг доошийгоо 2, 3, 4 хувь болгож бууруулах

боломж байгаа. Хэрвээ ингэж бууруулах тохиолдолд малчны төлөх даатгалын хураамж өсөх ийм эрсдэл байгаа учраас дундаж хувилбар нь 5-6 хувь юм байна гээд тухайн үед нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг хэлэлцэж байх үед ажлын хэсэг дээр яригдаад энэ тоо хувилбарыг гаргаж ирээд, одоо явж байгаа юм. 2021 онд нийтдээ 3,7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг нийт 21 аймгийн малчин өрхөөс цуглуулж авсан. Үүнээс 2022 онд 2021 оны өвлийн нөхөн төлбөрт 8,5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байгаа. Үлдсэн мөнгө, төгрөг хаачсан бэ гэдэг асуудал дээр хариултыг өгье. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд зааснаар 4 түвшний эрсдэлийн түвшин байгаа. Эрсдэлийн түвшин тус бүртээ алдагдлаас хамгаалах сан, Хамтын эрсдэлийн сан зэрэг даатгалын сангийн хуримтлал бий болдог. Эрсдэлийн сангийн мөнгө маань өөрөө жил болгон ашигтай байгаа тохиолдолд хуримтлагдаад явдаг нөхөн.../минут дуусав/

Н.Наранбаатар: 1 минут нэмээд өгчих. 3 номер дээр.

Б.Жавхлант: Нөхөн төлбөр олгогдоогүй нөхцөлд эрсдэлийн сан маань хуримтлагдаад явж байдаг. Ийм зориулалттай сан байгаа. Бид нар тест хийгээд үзэхэд жишээ нь 200-2011 онд хэрвээ тэр үеийнх шиг хохирол гарах юм бол 2021 оны хамрагдалтын түвшинээр аваад үзэх юм бол 11-12 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгох ийм тооцоолол гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ маань өөрөө юу вэ гэхээр хамтын эрсдэлийн сан, хуримтлалын сан, алдагдлаас хамгаалсан дунд түвшний эрсдэлийн санг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай. Ялангуяа 10 жил тутам ийм давтамжтай болж байгаа томоохон зудын эрсдэлд бэлтгэлтэй байх зорилгоор эрсдэлийн санг бол байнга хуримтлуулж байх шаардлагатай байдаг.

Нөгөө талаасаа олон улсын давхар даатгал дээр бид нар бас өндөр хэмжээний давхар даатгалынхаа эрсдэлийг гарган шилжүүлж байгаа. Энэ түвшний эрсдэлээ өмнө нь бол дээд түвшний эрсдэлийн хураамжийг бол Засгийн газраас төлдөг байсан бол 2021 оноос эхлээд үндсэн.../минут дуусах/

Н.Наранбаатар: Мөнх-Оргил гишүүнийг асуултад оруулчих. Микрофоныг нь өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Малын индексжүүлсэн даатгалын хууль дээр тэр босгыг Засгийн газар жил тутам шинэчилж баталж болно гэж байгаа шүү дээ. Тэгээд хууль батлагдсанаас хойш Засгийн газар энийг 6 хувийг, 20 хувийг шинэчилсэн, хөдөлгөсөн юм байна уу. 1 дүгээрт.

2 дугаарт яах вэ 11 хувь гэдэг бол нэг их ч бас чамлахаар тоо биш байгаа юм. Тэгэхдээ хамгийн гол нь наад даатгал чинь цаашаа яагаад өргөжихгүй байна гэхлээр сая яг Идэрбат гишүүний хэлж байгаатай адилхан малчдад нөгөө юу нь хүрэхгүй байна шүү дээ. Нөгөө үр шим нь очихгүй байна шүү дээ. Зүгээр л нэг зээл авахын тулд л хийхээс өөр аргагүй болоод л хүссэн, хүсээгүй хийгээд байна шүү дээ. Гэтэл даатгалыг чинь бид нар ярьж байгаад сайн дурын үндсэн дээр хийж байгаа нь надад ашигтай юм байна гэдгийг жишээ нь хажуу талын айлаасаа Ганболдоос би хараад Мөнх-Оргил би даатгуулж байх л тийм сонирхол үүсэх ёстой шүү дээ. Тэгээд наадхыг чинь хийх ёстой үндсэн арга механизмыг нь бид нар хуульд суулгаж өгсөн шүү дээ. Хагас жил тутам малын тооллого хий, тэгэхгүй бол бүтэн жил өнгөрсний дараа тооллого хийгээд, тэгээд тэр хооронд чинь өчнөөн үйл явдал болно. Тэр нөгөө малчин чинь нааш цаашаа нүүнэ. Малын тоо нь хөдөлнө, төрөл төрлөөрөө хөдөлнө. Тэгээд та нарт бол тэрийг төлөх ямар ч бололцоогүй хүнд байдалд орчихно шүү дээ. Тэгэхлээр 2 дахь асуулт. Энэ хуулийн

заалтыг яагаад хэрэгжүүлээгүй юм бэ Засгийн газар гэж.

2 дахь нь хагас жил тутам мал тоолох асуудлыг яагаад одоо болтол та нар хийдэггүй юм бэ. Энийг чинь хийхгүй болохлоор хууль хэрэгжихгүй нь ойлгомжтой шүү дээ.

3 дугаарт давхар даатгал та нар хаана хийж байна. Хэдэн төгрөг төлж байна. Давхар даатгалаасаа авсан мөнгө төгрөгөө төлсөн мөнгө төгрөг чинь эргэж буцаж орж ирж байна уу. Томоохон үйл явдлууд дээр байгалийн гамшиг гараад давхар даатгал дээр чинь мөнгө танай даатгалын компанид орж ирж байна уу.

4 дэх асуулт. Ер нь цаашидаа давхар даатгалын компаниар дамжуулаад хийгээд байх нь зөв байна уу. Эсвэл бие даасан тусдаа зөвхөн малын индексжүүлсэн даатгалаар явсан мэргэжлийн компани байх хэрэгтэй байна уу. Уг нь анх Дэлхийн банкттай ярьж байхад бид нар юугаар ярьж эхэлсэн юм. Газар тариалан дээр ярьж эхэлсэн байхгүй юу. Энэ бол газар тариалан дээр бол яг хэрэгжээд болоод байгаа юм. Яагаад гэвэл жишээ нь Сэлэнгэ аймаг газар тариалангийн бүс, тэнд ган, зуд болоход нутаг дэвсгэрээр нь бүрэн хамарчхаж байгаа учраас аж ахуйн нэгж цөөхөн, айл болгон дээр очоод өнөөдөр мал дээр байгаа малчид дээр биш нөгөө аж ахуйн нэгжүүд цөөхөн учраас газар тариалан дээр бол аягүй сайн хэрэгжих байхгүй юу. Тэгэхлээр энийг газар тариалан дээр туршиж үзэх ажлыг хамгийн түрүүн, 1 дүгээрт хиймээр байгаа юм. Малчдаас гадна газар тариалан. Тэгэхлээр та нар энэ хуулийг хэрэгжүүлэх явцад энэ хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд юу байна. Санаа оноо юу байна. Тэрийгээ Засгийн газраараа дамжуулаад Их Хуралд тавьсан юм байна уу.

Эцэст нь хурал даргалагч аа, би энэ олон жил Их уралд сууж байхад

байна шүү дээ малын хорогдол гээд Монголчууд би энэ Байнгын хорооны хуралд байнга суудаггүй л дээ. Тэгэхдээ малын хорогдол гээд Монголчууд бидний амьдралд хамгийн хүндээр тусаж байгаа, хамгийн ач холбогдол өгөх ёстой асуудал байгаа байхгүй юу. Ер нь танай яамны хийж байх ёстой гол асуудал. Гэхдээ байна шүү дээ би Улсын Их Хуралд ийм асуудлаар 3 хуудастай танилцуулга оруулж ирж байхыг би анх удаа харж байна. Ямар ч учир шалтгаан байхгүй, тайлбар байхгүй, арга зам байхгүй. Хууль дээр юу нь болж байгаа юм. Та нар ямар арга хэмжээ авсан юм. Юу хийх юм. Зүгээр л Статистикийн газраас ирж байгаа мэдээ шиг л тэдэн төгрөг даатгалын хуримтлалд авсан, тэдийг төлсөн.../минут дуусав/

Н.Наранбаатар: Хариулт хэнээс эхлэх вэ. 3 номер.

Б.Жавхлант: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Үндэсний давхар даатгал ХК 2014 онд анх байгуулагдсанаасаа хойш малын индексжүүлсэн даатгал, 2018 оноос газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүн туршилтын журмаар хийж хэрэгжүүлсэн. Яг хөдөө аж ахуйн чиглэлээр энэ 2-ыг бол яг индексжүүлсэн чиглэлээр хийж хэрэгжүүлээд явж байгаа. Ялангуяа давхар даатгал олон улсын давхар даатгагч нартайгаа 2006, 2007 оноос эхлээд нэлээн ойрхон ажиллаж байгаа. Олон улсын давхар даатгагч нартай. Энэ хугацаанд болохоор газар тариалангийн даатгал дээр бид нар 2020 онд нийт 400 гаруй аж ахуйн нэгжүүдийг даатгалд хамруулсан. Харамсалтай нь өнөөдрийг болтол даатгалын хураамжийн төлөлт бол 30 хувьтай, муу авлагатай явж байгаа. Өөрөөр хэлбэл зөрөөд бид нар олон улсын давхар даатгалаасаа 100 гаруй аж ахуйн нэгжүүдэд 360 гаран сая төгрөгийн нөхөн төлбөр олгочихсон ийм нөхцөл байдалтай явж байгаа. Ер нь бол яах вэ газар тариалангийн болон малын индексжүүлсэн даатгал дээр яг индексэд

суурилсан болохоор олон улсын давхар даатгагч нартай хамтран ажиллахад бол нэлээн ойр дөхөм байгаа. Олон улсын, Францын Скор болон Свистер зэрэг компаниуд бол манай малын индексжүүлсэн даатгал дээр нэлээн сайн ойлголттой, мэдлэгтэй байгаа.

Хагас жилийн мал тооллого бол жил болгон хийгдэж байгаа. Малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр бол жилийн эцсийн мал тооллогоос хагас жилийн мал тооллогын хооронд гарсан зөрүүгээр нөхөн төлбөрийг тооцож олгож байгаа. Энэ систем маань одоо болтол явагдаж байгаа. Нөхөн төлбөрийн тооцооллыг хагас жилийн мал тооллогын дүнд үндэслээд Статистикийн газар хагас жилийн мал тооллогыг гардан гүйцэтгэдэг. Энэ маань 5 сарын сүүлээс 6 сарын эхний хагаст багтаагаад хагас жилийн мал тооллогын үйл ажиллагааг хийгээд, хэрэгжүүлээд нэгтгэсэн тайлан дүн мэдээгээ 7 сарын 15-20-ны хооронд нэгтгэж өгдөг. Үүний дараа нөхөн төлбөрийн тооцоолол гараад явдаг. Ийм систем одоо болтол явагдаж байгаа.

Босго үзүүлэлтийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд зааснаар босго үзүүлэлт Засгийн газар 3 жил тутам тогтооно гэж байгаа. Хамгийн сүүлд Засгийн газар бол 2020 онд босго үзүүлэлтийг 5-6 хувиар аймаг тус бүрээр тусгаарлан гаргасан байгаа. Энэ жил 2023 онд Засгийн газар энэ 5-6 хувийн босго үзүүлэлтийг дахин шинэчлэн тогтоох байгаа.

Н.Наранбаатар: Мөнх-Оргил гишүүн тодруулъя.

Ц.Мөнх-Оргил: Та түрүүн Өнөрболор гишүүний асуултад хариулж байхдаа хагас жилийн мал тооллого хийхгүй болохоор л бид нар нөхөн төлбөр олгож чадахгүй байна гэсэн л юм ярьчихлаа гэж би ойлгосон шүү дээ. Одоо надад болохоор төлөөд байна гэж. Тэрийгээ нэг тодруулчхаач.

2 дугаарт малчдад энийг сурталчилдаг арга зам чинь юу байдаг юм бэ. Яаж хүргэдэг юм бэ. Танай компани хэр ашигтай ажилладаг юм хэдэн хүн байдаг юм. Үүний үр шимийг малчид үнэхээр хүртэхгүй байгаа бол жишээ нь 2022 онд та нар ингэсэн байгаа 3,9 тэрбумын хураамж цуглуулаад, нөхөн төлбөрт нь 5,8 сая төгрөг өгсөн байгаа байхгүй юу. Жишээ нь 2021 онд. 2022 онд 3,9 тэрбум төгрөгийн хураамж.../минут дуусав/

Н.Наранбаатар: Дахиад 1 минут Мөнх-Оргил гишүүнд.

Ц.Мөнх-Оргил: Тэгээд жишээ нь ийм юм байх ёстой юм шиг санагдаад байх юм чинь. Аймаг болгон сум болгон чинь өөр өөрийн онцлогтой байгаа шүү дээ. Зарим нь илүү зудархуу байгаа, зарим нь илүү ганд өртөж байгаа. Тэгэхээр тэр аймаг болгонд нь өөр өөр босго тавьж өгөхгүй зүгээр улсын хэмжээнд 5, 6 хувь гэхихээр чинь жишээ нь наадах чинь малчдад ямар ч сонирхолгүй байна шүү дээ. Жишээ нь зудад нэрвэгддэггүй бид нар бол гайгүй дээ зуд бол манай нутагт гайгүй дээ гэж бодож байгаа малчин бол хэзээ ч тэрэнд чинь орохгүй шүү дээ. Манайх бол байнга зудтай байдаг юм гэж бодоод орчихдог. Тэгсэн чинь дараа жил нь зудгүй өнгөрчихвөл нөгөө малчин чинь тэрний дараа жилээ дахиад юунд орохгүй шүү дээ, даатгалд хамрагдахгүй шүү дээ. Тэгэхээр энэ чинь бас урт хугацаатай байх ёстой юм биш үү. Тэгж байж нөгөө малчин чинь үр шимээ хүртдэг юм биш үү. Энэ босгоо ялгавартай тогтоох ёстой байсан юм биш үү. Зүгээр улсын хэмжээнд бүгдийг нь 5, эсвэл бүгдийг нь 6 гээд. Эсвэл зарим аймаг нь 5, зарим аймаг нь 6. Тэгсэн мөртөө төрөл төрлөөр нь гээд бид нар.../минут дуусав/

Н.Наранбаатар: 3 номерын микрофон өгье.

Б.Жавхлант: Мөн-Оргил гишүүний асуултад хариулъя. “Үндэсний давхар даатгал” ХК Өнөөдөр нийт ажиллагсдын тоо 40 байгаа. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 2,3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан 100 хувь төрийн өмчит хувьцаат компани байгаа. Малын индексжүүлсэн даатгалын сурталчилгааг хамтран ажиллаж байгаа 8 даатгалын компани, 2 арилжааны банк, Төрийн банк, Хаан банкны сувгууд болон үндэсний давхар даатгал компани өөрсдийн хэвлэл мэдээлэл олон нийтийн харилцах сувгуудаар болон сошиал, цахим орчинд малын индексжүүлсэн даатгалын сурталчилгааг дамжуулан хүргэн ажиллаж байгаа. Босго үзүүлэлтийг болохоор зэрэг 2020 онд аймаг болгонд ялгавартай байдлаар тогтоогоод өнөөдрийн байдлаар 6 хувийн босго үзүүлэлттэй 6 аймаг байгаа. Бусад нь 5 хувь дээр байж байгаа.../минут дуусав/

Н.Наранбаатар: Дахиад 1 минут нэмээд өгчих. 3 номер.

Б.Жавхлант: Энийг болохоор зэрэг яг хууль дээр 6 хувь гэсэн байгаа зүйлийг бид нар өөрчлөх саналыг боловсруулаад явж байгаа. Өнөөдрийн байдлаар гэхэд бас 4 хувийн босго үзүүлэлт рүү орох боломжтой 6 аймгийн 30 гаруй сумдын нутаг дэвсгэр бас хамрагдсан ийм 80 билүү, 80 гаруй сумдын ийм нутаг дэвсгэр бол 4 хувийн босго үзүүлэлттэй байх боломжтой. Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацаанд хийгдсэн судалгаагаар тийм байгаа. Тэгэхээр бид нар энийгээ бас боловсруулаад Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яаманд бас 4 хувийн босго үзүүлэлт байж болох юм байна гэдэг. Тэгж байгаа. Ерөнхий 5-6 хувь гэдэг бол 1981 оноос хойших статистик тоонд тулгуурласан. Ерөнхий тоо нь бол одоо бид нарт байж байгаа тоо мэдээ, малын хорогдлын тоо болон малын индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлж.../минут дуусав/

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлж болно. Гишүүд нэрсээ өгье. Ганболд гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Мөнх-Оргил гишүүн яг ярьж байна л даа. Үнэхээр Хөдөө аж ахуйн яамны гол анхааралд байх ёстой энэ сэдэв өнгөрсөн 7 хоногийн Байнгын хороон дээрээс асуухад тэс хөндлөн ямар ч хамааралгүй юм ярьж байгаа юм шиг л ийм хариулт авсан. Миний хувьд бас гайхсан энийг. Яг үнэнийг хэлэхэд. Тэгэхээр энэ чинь мал, малчин бүгдийг нь л бодлогодоо бас тусгаж явах ёстой. Малчингүй боллоо л гэж яриад байгаа. Үгүй ээ, малчин руугаа харсан, анхаарсан юмаа яам чинь ер нь хийхгүй байгаа юм биш үү гэж миний хувьд шүүмжлэх гээд байгаа шүү. Энэ даатгал хэрэгжээд 17 жил болж байна. 2006-2014 оны хооронд туршилтын үе явж, 2014-2023 он гээд 9 жил явж. Өнөөдөр та нар тэгэхээр яг энэ даатгалын системийг малчинд үр ашигтай болгох талын ямар нэгэн арга хэмжээ бас хийсэн юм уу, хийгээгүй юм уу. Би бол бас хууль эрх зүйн орчин одоо л Мөнх-Оргил гишүүн бараг хэл амыг нь сугалчих шахаж байж л асуулаа. Одоо л нэг юм боловсруулаад явж байгаа гэсэн ийм л зүйлийг хэлж байна шүү дээ. Тэгэхээр энэ даатгал хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Хэзээ хэрэг нь гардаг вэ гэхээр ёстой нөгөө дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу үед л хэрэг болох ёстой. Гэтэл ирж байгаа хариу нь хагас жилийн малын тооллого. Хагас жилийн малын тооллого чинь түүврээр явдаг шүү дээ. Жилийн эцэс шиг явдаггүй шүү дээ. Та нар тэрийг хэлэхгүй байна шүү дээ. Түүвэр гэдэг чинь тухайн сумаас хэдэн айлаар очоод тоолоод л багцаа гаргаж ирдэг шүү дээ. Гэтэл малчид чинь малаа ширхэгчлэн даатгуулчихсан байгаа шүү дээ. Тэгээд даатгуулж байгаа систем чинь даатгалын нөхөн төлбөрийг олгож байгаа 2 тооллого хийж байгаа арга чинь буруу байгаад байгаа юм биш үү. Тэгээд л нэг багцаа гаргаж ирээд л. Тэгээд эндээс

чинь асар олон хүн хохироод байгаа учраас сүүлийн 4 жилийн байдлаар даатгалд ирж байгаа, хамрагдаж байгаа хүмүүсийн тоо байхгүй байна шүү дээ.

Энэ чинь сайн дураараа биш зайлуул аргаа барахдаа л даатгуулсан. Танайх Хаан банк, нэг нь Төрийн банк гэсэн байх. Энэ 2-оор зээл олгож байгаа учраас зээл даатгалтай байх учраас л өгч байгаа юм. Тэрнээс даатгалын үр шимийг авчих юм сан, хүртчих юм сан гэх нэг ч хүн байхгүй. Тэгэхээр та нарын даатгалын зорилго чинь бол бас үндсэн үүргээ биелүүлж чадахгүй байна. Танай байгууллага тэгээд 2 тэрбум гаруй төгрөгийн ашигтай ажиллаад байдаг. Танайхыг бүрдүүлж байгаа малчид чинь тэнд хохироод байна шүү дээ. Ер нь бол. Тэгэхээр энэ тал дээр нэг жоохон малчнаа гэсэн юмыг бас хиймээр байна. Таны юунаас Олон улсын давхар даатгал гэхэд л газар тариалан дээр бас амжилтгүй явж байгаа юм байна шүү дээ. 30 хувь нь л дөнгөж өгч байгаа. Малын эрсдэлийн даатгал руу олон улсыг оруулж ирвэл бүүр бүтэхгүй юм байна шүү дээ. Тэгэхээр иймэрхүү дүр зурагтай байгаад байдаг. Тэгэхээр миний санал бол салбарын яам нь Сангийн яамны харьяанд байгаа Үндэсний давхар даатгалтай нэлээн бас хамтарч ажиллаж, малчдынхаа санал онолыг сонсож, хууль, эрх зүйн хувьд өөрчилж малчдадаа жоохон тийм ээлтэй, маш шуурхай тогтолцоог үүсгэх талын юмыг бас би яамыг нэлээн тийм идэвх санаачилгатай ажиллаасай гэж ингэж хүсээд байгаа юм. Үндэсний давхар даатгал гээд би 2014 оны хуулийг бас нэлээн сайн харсан. Мал аж ахуйг л бас даатгалд хамруулж л байх юм байна гэж ингэж ойлгосон. Алдагдлын сан гэж би үүсгэж байгаа юм байна. Тэгээд энэ Алдагдлын сан чинь хэзээ яг тийм эргэлтэд орох юм бэ. Зүүн аймгуудад болсон саяын гамшигт үзэгдлийг алдагдлын сангаас янз янзын юм байхгүй юу. Нэг л өдөр болно доо гээд яваад байх юм. Тэгээд та нар жоохон шуурхай ажилламаар байна. Орон нутагт хүн

гамшигт өртчихөөд маргааши нь тэгээд л газар дээр нь шуурхай арга хэмжээ авч байж тэр хүн зайлуул жоохон сэтгэлийн дэм авдаг юм шүү дээ. Та нар бол аягүй хөндий яриад байгаа байхгүй юу. 6 сар тооллого, наад нэг түүврийн тооллого чинь 7 сар гарна. Наадам болно. Тэгээд л 7 сард жоохон жоохон юм өгдөг юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ процесс эд нарыг нэг жоохон хурдлуулаад гамшигт үзэгдэл боллоо л бол хариу арга хэмжээг даатгалын компаниуд хурдан авч болдоггүй юм уу. Малчид автомашины даатгал шиг л юм бодож байгаа шүү дээ. Даатгал гэхээр чинь. Мөргөлдөө маргааши нь нөгөөдөр нь тэр дор нь л арга хэмжээ аваад байдаг.

Малчдынх гэхээрээ яахлаараа хэдэн сараар хойшлуулаад тавьчихдаг юм. Тэгэхээр би бол та нар малчдын асуудал дээр жоохон тийм нэг жоохноор барахгүй нэлээн сэтгэл гаргаад, ажиллаад, малчин хүний сэтгэлийг өмнөөс нь энийг нэг бодож үзээд тэгээд мэдээж даатгалынхаа тогтолцоог нураачхаж болохгүй. Гэхдээ нэг талаа бас хохироогоод байж болохгүй шүү дээ. Тэгээд жоохон шуурхай арга хэмжээ авдаг, хариу арга хэмжээний процесс нь маш хурдан, малчдад ойлгомжтой, сурталчилгаа эд нар бол 2006-2014 оны хооронд л яг тэр төслөөр явж байх үед л нэлээн эрчтэй явдаг байсан даа. Одоо бол зогссон шүү дээ наадах чинь. Угаасаа малчид зээл авахын тулд, шагнал авахын тулд даатгал гэдэг ийм л юм байгаа юм. Тэгэхээр би яамнаас бол.../минут дуусав/

Н.Наранбаатар: Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Миний хувьд Байнгын хорооны даргад нэг зарчмын юу гэдэг юм санал гэх юм уу, шүүмжлэл гэх юм уу бас нэг зүйлийг хэлчихье гэж бодож байна. Байнгын хорооныхонд. Ер нь юу гэдэг юм орж ирж байгаа материал, мэдээлэл, танилцуулгууд улс орны маш чухал асуудлууд. Тэгээд дээрээс нь бас хариуцлагатай судлах

ёстой, том агуулгаар нь харах юм бол бараг үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбоотой ийм асуудлууд орж ирж байхад чинь 10, 20 минутын өмнө л бид нарт ингэж материал тараадаг нь үнэхээр хариуцлагагүй байна. Хэрэв өнөөдөр яамнуудаас энэ материалууд нэг өдрийн өмнө л ийм ач холбогдолтой асуудлуудаар ирэхгүй байгаа тохиолдолд энэ асуудлыг бол хойшлуулаад ч юм уу, дараагийн Байнгын хороогоор оруулж байх ийм шаардлагатай. Тэгэхгүй бол сая бүх гишүүд л хэлж байна шүү дээ. Гуравхан хуудас дээр танилцуулга, мэдээлэл явж байгаа. Агуулга нь ч гэсэн өөрөө маш муу дутмаг, шийдэлгүй, саналгүй, тэгээд ийм тэгээд дээрээс нь орж ирж байгаа танилцуулгууд чинь бид нар чинь аягүй олон ийм материал дээр ажиллаж байгаа учраас үнэхээр цаг хүрэлцэхгүй байна. Ийм хариуцлагатай хандах ёстой асуудал дээр тун хариуцлагагүй хандаж байна. Тийм учраас Байнгын хорооныхон бол энэ дээр анхаарлаа хандуулна биз ээ гэж хэлье.

Тэгээд би тэр сая Сэлэнгийн малчидтай холбоотой асуудлыг хэлж байна л даа. Ер нь байна шүү дээ. Нэг төрийн үйл ажиллагааг хараад л ярилцаад байхаар ерөөсөө л нэг бие бие рүү нь шидсэн хариуцлагагүй. Тэгээд л ерөөсөө малчдын буруу, малчдын хариуцлагагүйгээс ч гэдэг юм уу ийм асуудал ярьж байгаа нь бол иргэндээ ээлгүй бодлого бол явж болохгүй л дээ. Үндсэндээ энд ерөөсөө л нэг асуудал байгаад байгаа нь юу гэж байна вэ гэхээр мэдээлэл дутмаг асуудал нэн ялангуяа иргэдэд маш их байдаг. Ерөөсөө огт ойлгодоггүй байгаа байхгүй юу. Би ийм асуудал үүсчих юм бол би хэнд хандах ёстой юм. Тэгээд энэ асуудлаас үүдээд улбаалаад хүмүүс юу гэж хэлж байна гэхээр гарсан хариуд нь би итгэхгүй байна гээд. Малчид хүртэл. Яагаад гэхээр бараг харлачхаж байгаа байхгүй юу. Хотхон нь тэр чигээрээ бараг малгүй болчхож байгаа болохлоор чинь тэр чинь юу гэсэн үг юм бэ. Маш том гарз хохирол

учирч байхад чинь тэгээд устгалд л оруулж байгаа болохоос биш яг малчин хүний нөхцөл байдалд маш том гарз хохирол байгаа байхгүй юу. Тэгээд энийг хаа хаанаа энэ уялдаа холбоогоо бодлогоор хангах, шийдвэрээр хангах хэрэгжүүлэхдээ уялдаа холбоотой байх асуудал дээрээ төр бас хариуцлагатай байх ёстой ийм асуудал гарч байна гэдгийг би бас давхар хэлмээр байна.

Нөгөө талаасаа гэхээр Сэлэнгэ аймаг байна шүү дээ аль дээр үед л эрчимжсэн мал аж ахуйн ийм бодлого шийдвэр гарсан шүү дээ. Сэлэнгийн хувьд. Тэгээд бараг 10 гаруй жил байна шүү дээ энд ямар ч бодлого байхгүй байгаад байна. Ерөөсөө л би яаманд бол урт удаан хугацаагаар олон жил ажиллаж байгаа газрын дарга нар мэдээж хариуцлагатай сайн ажиллаж байгаа, нээлттэй ажиллаж байгаа, явал зүгээр вэ бодлогоор хангаж өгдөг. Энэ яаманд ирсэн сайд нарын түвшинд бодлогыг гаргахдаа маш ороо бусгаа байна гэж бол харагдаж байгаа. Яагаад тэгсэн бэ гэхээр би өмнө нь бол Мэндсайхан сайдад ч гэсэн энэ асуудлыг бол тавьж байсан. Тэгээд маш хүнлэг бус хариулт хэлж байсан. Манай яамныхан ч гэсэн мэдэж байгаа. Ерөөсөө л малчдыг бараг шахуу газар тариалангийн бүсээс хөөгөөд гаргана л гэж байгаа байхгүй юу. Үгүй ээ, юу гэсэн үг юм бэ. Тэгээд үүнтэй холбоотойгоор маш их олон сөрөг үр дагавар гарна гэдгийг тэр хүн ч гэсэн өөрөө ойлгож мэдэж байгаа. Энэ чинь хаа хаанаа зохицуулалтаар бодлогоор хангах ёстой болохоос биш. Тэгээд одоогийн сайд бол энэ дээр ерөөсөө байр сууриа илэрхийлэхгүй байгаа. Асуугаад байгаа. Тэгээд дэлхий даяар хүнсний хангамж, аюулгүй байдлын асуудал ноцтой яригдаж байгаа. Үүнийг Монгол Улсын хувьд гэх юм бол өнөөдөр стратегийн ач холбогдол боломж гэдэг агуулгаасаа бид нар хараад дээр илүү зөв бодлого, шийдвэр, шийдэлтэй уялдах юм бол өнөөдөр бид нарт маш том боломж байгаа гэдгийгээ бодлогын түвшинд авч үзэх хэрэгтэй байгаад байна. Дээрээс нь

орон нутгийн удирдлагуудтай яг ямар түвшинд тэд нар юуг нь хариуцах юм, яам ямар бодлогоор хангах юм, малчид болон ногоочид яаж энэ асуудалд ингэж зөв боломжоор хамрагдаж оролцох юм. Энэ үүрэг хуваарилалтууд, бодлого, хэрэгжилт, шийдвэр тал дээр нэг л дутмаг, уялдаа холбоо маш муу байгаад байна аа. Тийм учраас л манай улсын хэрэгжилт байнга унаж байгаа шүү дээ. Бүх талаараа ерөөсөө Засгийн газрын ч хэрэгжилт, Хүнс хөдөө аж ахуйн яамны ч зорилго зорилтууд өнөөдөр 30-аас дээшийгээ гарч чадахгүй байгаа энэ хэрэгжилт чинь угаасаа л уялдаа холбоотой маш холбоотой байгаад байгаа байхгүй юу. Тэгээд цаасан дээр маш сайн тунхаглаж зохицуулалт хийж чадаж байна. Гэтэл амьдрал дээр.../минут дуусав/

Н.Наранбаатар: Мөнх-Оргил гишүүн үг хэлье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Би түрүүн танилцуулсан материалын тухай хэлсэн. 2 хуудас гээд. Жишээ нь манай Хөдөө аж ахуйн яамныхан харж бай. Энэ бол би Нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулах гэж байгаа асуудал. Ийм материал орж ирж байгаа байхгүй юу. Нийгмийн бодлогын байнгын хорооныхон ийм материал хүлээж авч байгаа. Энэнээс өөр материалыг хүлээж авахгүй бид нар 2 удаа буцааж байгаа юм. Өнөөдөр Байгаль орчны яамнаас бэлдүүлж ирж байгаа материал нь энэ. 4 конвенцын хэрэгжилтийн асуудлаар ийм материал бэлдүүлж, өөр цаана нь зөвлөмж гээд 20-иод хуудас юм байгаа юм. Ийм судалгаатай орж ирж баймаар л байгаа юм л даа. Тэгээд Статистикийн газар шиг нэг хэдэн тоо тавьчхаад ороод ирэх юм. Та нар 1 дүгээрт анхаарах хэрэгтэй байх. Залуу сайд дарга нар. Өөрийнхөө сайдад ч гэсэн хэлнэ биз.

2 дугаарт байна шүү дээ. Манай иргэдийн мэдээж тэр дундаа манай малчдын ерөнхийдөө бүхэлдээ даатгалын тухай ойлголт сул л даа. Бид нар л энд

нөгөө хууль хийж байгаа учраас л даатгал ийм ийм гээд л ерөнхийдөө гадарлаад байгаа болохоос биш. Тэгэхдээ тэр хүмүүсийн даатгалын мэдлэг нэмэгдсэний дараа та нар даатгалынхаа хамралтыг нэмэгдүүлээд нөхөн төлбөрийнхөө хэмжээг нэмж өгөөд явна гэвэл бүтэхгүй шүү дээ. Тэгэхлээр хууль, эрх зүйн аргаар ямар хөшүүрэг бий болгож байна тэр саналуудаа оруулмаар байгаа юм. Тэрийг хүлээлгүйгээр. Мэдээж хажуугаар нь мэдлэгийг нь сайжруулах л хэрэгтэй байх л даа. Тэгээд энэтэй холбогдуулаад надаа нэг ийм санал байна. Байнгын хороо миний бодлоор ажлын хэсэг гаргамаар юм байна гэж би зүгээр бодож байна. Эдний яамныхныг дэд ажлын хэсэгт оруулаад өөрсдөө ажлын хэсэг гаргаад яг энэ 10 хэдэн жилийн дотор Малын индексжүүлсэн даатгалын хуулийн хэрэгжилт ямар байна. Проблем нь хаана байна гэдгийг бүр өөрсдөө энэ зузаан материал шиг гаргаж ирээд тооцоон дээр суурилад, ямар нэгэн сэтгэлийн хөдөлгөөнөөр яг актуард тооцоонуудыг нь хийгээд гаргамаар байна. Тэгээд хамгийн гол асуултад ерөөсөө цаашдаа малын индексжүүлсэн даатгал хэвээрээ байх юм уу, үгүй юу гэдэг дээр маш тодорхой хариулт өгмөөр байна. Миний бодлоор өнөөдөр хийсэн хэлэлцүүлгээс бодохлоор надаа бол ямар сэтгэгдэл төрж байна вэ гэхээр ерөөсөө манайх шиг ийм нүүдлийн мал аж ахуйтай, бэлчээрийн мал аж ахуйтай газар магадгүй малын индексжүүлсэн даатгал бол үйлчлэхгүй юм байна. Фермерийн аж ахуйд хөгжчихсэн газар бол энэ хөгжиж магадгүй. Үр дүнгээ өгч магадгүй. Тариаланд магадгүй, газар тариалан дээр магадгүй. Тэгэхээр индексжүүлсэн даатгалыг зүгээр ерөөсөө арилжааны даатгалаар солиод үзэх ч арга зам байж магадгүй. Тэгэх юм бол шууд малчин Ганболдын хохирлыг л нөгөө арилжааны компани чинь дор нь төлөөд л төлөөд л явчихна шүү дээ. Нөгөө хагас жилийн даатгал, энэ чинь нөгөө яг өөрийнх нь хотонд учирсан хохирол төлөгдөхгүй шүү дээ. Нийт

сумаараа хохирол амсаж байж төлөх ёстой байхгүй юу. Тэгтэл нөгөө хүн чинь өөрөө малаа хамгаалаад үлдчихсэн байдаг. Сумынх нь малаа хамгаалаад үлдээгүй бол бүгдээрээ нөхөн төлбөр аваад байдаг. Нэг хэсэг нь ерөөсөө малаа хамгаалаад үлдчихсэн, нэг нөхөр авч үлдээгүй байх юм бол тэр нөхөр бас давхар давхар хохироод үлдчихдэг. Дандаа нөгөө сонирхлууд нь зөрчилдөх тийм их том мөнгөний эрсдэл байна. Тийм учраас нэг бүсийг нь судлаад үзвэл яадаг юм бэ? Тэгээд малчдаа арилжааны даатгал руу нь оруулаад, энэ чинь өмчийн даатгал байхгүй юу. Өмчийн даатгал, хариуцлагын даатгал бол албан журмынх байж болж байгаа юм. Заавал даатгаж болж байгаа. Хариуцлага учраас. Чи хүнийг хохироочихсон учраас чи хариуцлагаа төл гээд албан журмаар шахаж болж байгаа юм. Энэ чинь өмчийн даатгал учраас албан журмаар шахаж болохгүй байхгүй юу. Тийм учраас өмчийн даатгал учраас сайн дурынх нь 1 дүгээрт хамгийн гол нь арилжааных руу нь оруулаад, тэгээд арилжааны компаниудаараа хийлгэвэл яадаг юм бэ гэдгийг судалж үзмээр юм байна. Энийг та хэд нэг судлаадхаач.

Тэгээд би бол ийм саналтай байна. Байнгын хороо ажлын хэсгээ гаргаад, дүгнэлтээ гаргаад, Байнгын хороон дээрээ хэлэлцэхдээ энийг байна шүү дээ заавал нэгдсэн хуралдаан дээр орж хэлэлцүүл. Бусад Их Хурлын гишүүдэд энэ асуудлыг танилцуулах хэрэгтэй. Байдал ийм байна шүү. Энийг ингэвэл яасан юм бэ гэж. Энийг улсын түвшинд авч хэлэлцэхгүй бол ерөөсөө хэрэгжихгүй юм байна.

Тэгээд ажлын хэсэг дүнгээ танилцуулахдаа хэрвээ цааш нь авч явна гэх юм бол хуулиа яаж өөрчлөх юм. Авч явахгүй гэвэл нөгөө арилжааны даатгалдаа шилжинэ гэх юм бол ямар зохицуулалт оруулах юм гэдэг хууль нь биш ч гэсэн ерөнхий санаануудыг нь тусгаж өгмөөр байна. Яг ийм ийм санаанууд дээр концепцыг нь оруулж

ирээд тэгээд тэрийгээ хэлэлцүүлээд болохгүй бол Их Хурлын тогтоол гаргаад Засгийн газарт даалгавар өгөөд энийг ингэж ингэж засаад ийм хууль болгоод оруулаад ир гэдэг чиглэл өгмөөр юм байна. Тэгж байж наадах чинь нэг тийшээ явахгүй бол одоо яг энэ янзаараа бол хэдэн ч жил яваад 11 хувь чинь 12, 13 хувьтай л үлдэх юм байна. Танайх жилийн... /минут дуусав/

Б.Саранчимэг: Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Яг л тэгж л харагдаж байна л даа. 2021 оны тэр хураамж нь 3,9, нөхөн төлбөр нь 5,8 гээд бодохоор яг сая Мөнх-Оргил гишүүний л дүр зураг харагдаж байна л даа. Зүгээр яах вэ цэвэр арилжааны хэлбэр рүү гэх юм бол бас л босго энэ тэр бас нэлээн өндөр, арилжааны хураамж, даатгалын хураамж нэлээн өндөрсөх магадлалтай гэж хараад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ дээр байна шүү дээ Засгийн газар бол 3 жил тутамд босго үзүүлэлтээ эргэж хараад, яаралтай арга хэмжээ авах болчихсон байна. Одоо бид нар байна шүү дээ. Ган, зуд гамшигаа ялгахгүй бол болохгүй. Ган зуд бол өөр байна. Гамшиг бол зурвасхан ерөөсөө 1 эвгүй газар буучихсан, хэдхэн айлыг нэрвээд л гарах магадлалтайг бол сая зүүн аймгуудаар харлаа шүү дээ. Тэгэхээр одоо ерөөсөө гамшигийн юмнууд дээр бол ерөөсөө босго тавихгүйгээр явж үзээд, хэрэв тэр дээр нь малын индексжүүлсэн даатгал маань хураамжаараа нөхөн төлбөрөө дийлэхгүй бол харин төр тэр дээр нь дэмжлэг үзүүлдэг ийм хэлбэр рүү орохгүй бол болохгүй байгаа юм. Одоо яг та нар яг энэ хэлбэрээр яваад байх юм бол ган, зуд дээр ч гэсэн ялгаа байхгүй. Нэг сумд ган, зуд боллоо. Боломжтой айлууд нь отор нүүдэл хийгээд яваад өгч байгаа юм. Тэд нар нь эрсдэлээс гараад явчихна. Нүүх боломжгүй хэд нь үлдээд, тэндээ нэрвэгдээд л, тэгээд л нөгөөдөх нь нөгөө 6 хувьдаа хүрэхгүй, тэгээд л ерөөсөө даатгал хүртэхгүй л яваад байна. Сая яг Мөнх-Оргил гишүүний хэлдэг шиг танайх

жилд нэг хэдэн төгрөгийн ашигтай, тэр нь яг нарийндаа банкнуудаас зээл авахад заавал даатгалд хамрагдсан байх ёстой гэдэг ийм л юм яваад байгаа учраас түрүүн миний хэлсэн ноос, арьс ширний урамшууллаас бид нар чинь нийгмийн даатгалыг төлөх ийм хууль санаачилга батлуулсантай адилхан тэр урамшууллаар нь харин малын индексжүүлсэн даатгалд даатгадаг ийм хэлбэр лүү оруулж байж хүрээгээ тэлж, хураамжаа өндөрсгөөд тэгээд хураамж хэдийгээр өндөр байх тусам танай босго яг эсрэг хамаарлаараа буугаад л явах ийм л зарчим руу орж байх ёстой л доо.

Тэгээд нөгөө талаар ер нь манайх нэг жоохон ойлгомжтой хэлбэр рүү орохгүй бол саяын Өнөрболор гишүүний хэлээд байгаа малын гоц халдварт өвчин гарна. Тэгээд дараа нь баахан устгал хийнэ. Өмнө нь нөхөн төлбөр олгодог байсан. Одоо яг олгож байгаа үгүйг нь мэдэхгүй байна. Сүүлийн үед ер нь олгохгүй нэлээн асуудлууд зөндөө байгаа юм аа. Тэгээд дээр бас Мал эмнэлгийн ерөнхий газар ойлгомжтой болохгүй бол зарим газар устгаж байн, зарим газар нь устгахгүй. Тэр битгий хэл танай ерөнхий эмч нэг эмэгтэй байсан юм даа. Бараг идчихэж болно доо. Шүлхий туссан малыг 24 цаг загсаагаад л тэгээд л шүлхий нь байхгүй болчихдог юм шүү дээ. Тэгэхээр нь хүнсэнд хэрэглэхэж болно гээд л яриад явж байсан. Би өөрөө сонсоод л сууж байсан. Гэтэл зарим газар ерөөсөө устгахгүй бол болохгүй баларлаа гээд л өчнөөн амьтны мал, үхэр 100, 100-аар нь устгаад л тэгээд нөхөн төлбөрөө авч чадахгүй бөөн уйлаан майлаан. Зарим газар нь тэгээд л шууд нядлаад л идчихэж байгаа шүү дээ. Шууд хуушуур луу явуулчхаж байгаа юм. Тэгээд энийгээ та нар нэг жоохон ойлгомжтой болгож, аймаг болгонд устгах юм уу, үгүй юу. Устгах юм бол яг хэдэн төгрөг олгох юм. Эсвэл ерөөсөө шүлхийд ерөөсөө устгахгүй юм уу. Сүүлийн үед л би устгахгүй л бодлого барьж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд энийгээ нэг жоохон ойлгомжтой болгоод, ямар

өвчин дээр устгах юм, ямар өвчин дээр устгахгүй юм. Хэрэв устгах юм бол яг нэг эх малд нь юм уу, эцэг малд нь юм уу, төл малд нь тийм гээд журмаа жаахан тодорхой болгоод, эрсдэлийн нөхөн олговор олгодог ийм хуультай болохгүй бол зөвхөн малын индексжүүлсэн даатгалыг хараад Идэрбат гишүүний хаврын зүүн аймгуудын нүд халтирам эрсдэлүүд дээр нөхөн олговор ч юм уу, дэмжлэг үзүүлэх ямар ч хууль байхгүй төрөөс. Тэгээд энийг дан даатгал руу хаяад явна гэх юм бол бүтэхгүй. Тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу шилжүүлсэн гээд тэнд чинь юу ч байхгүй. Батлагдсан мөнгө байдаггүй. Тэгээд энийг ерөөсөө тусгайлан сая гишүүдийн хэлж байгаачлан яам өөрөө ерөөсөө яг тодорхой бодлого оруулж ирээд Байнгын хорооноос ямар шийдвэр гаргуулах юм, ямар тогтоол гаргуулж Засгийн газарт үүрэг, чиглэл өгүүлэх юм. Эсвэл ямар хуульд тодорхой өөрчлөлтүүд ормоор байгаа юм гэдэг ийм тодорхой санал оруулж ирэхгүй нэг ийм юм оруулж ирээд л, нэг хэлэлцсэн болоод л, тэгээд л дэмий яриад л хэдүүлээ ярьж байгаад л салдаг нэг ийм л юм болоод байна шүү дээ. Ямар ч үр дүн байхгүй. Тэгээд үр дүн гаргахын тулд ийм гамшиг эрсдэл гарлаа. Энэнээс гарахын тулд ийм арга зам хэрэгтэй байна. Шийдвэрлэх гэдэг ийм юмаа л давхар яамнууд оруулж ирэхгүй бол бид нар энд хий дэмий цагаа барж хэдэн тоо хараад сууж байх ямар ч шаардлага алга. Таны түрүүний тоонуудыг би хэлсэн шүү дээ. Улаан загалмай нэг жоохон.../минут дуусав/

Б.Саранчимэг: Ганболд гишүүнд баярлалаа. Тэгэхээр маш чухал асуудал. Тэгээд түрүүн бол манай Идэрбат гишүүнээс эхлээд маш олон гишүүд ер нь энийг Байнгын хороогоор хэлэлцье гээд өнөөдөр хэлэлцэж байгаа. Тэгэхээр гишүүд бол их маш үнэтэй саналуудаа, тодорхой саналуудаа хэлж байна. Хамгийн гол нь бас энэ асуудлыг өнөөдөр хэлэлцээд дуусах биш, дараагийн Байнгын хороогоороо ажлын хэсгийн тогтоол

гаргаад, тэгээд ажлын хэсэг гаргаад ажиллая гэсэн ийм саналтай байна. Гишүүд үг хэлж дууслаа.

13.30 цаг.

Дараагийн асуудал. Монгол Улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг сонсоно.

Тэгэхээр мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 9 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох Олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан Олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил танилцуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Цэрэндулам Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт бодлогын төлөвлөлтийн газрын дарга, Уранчимэг мөн яамны Байгалийн нөөц бодлого зохицуулалтын газрын дарга ирсэн үү. Буяннэмэх мөн яамны Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газрын дарга, Батжаргал Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газрын Химийн бодис хариуцсан шинжээч, Оюун Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газрын Хог хаягдлын асуудал эрхэлсэн ахлах мэргэжилтэн, Мөнхдөш Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын Амьтны асуудал хариуцсан мэргэжилтэн, Ариунтуяа Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн Олон талт хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Ундармаа Монгол улс Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хэрэгжилтийн үндэсний 4 дүгээр тайлан,

илтгэл болон хүлэмжийн хийн ялгарал шингээлтийн 2 жил тутмын 2 дугаар тайлан, илтгэл боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх төслийн зохицуулагч, Ундрах Хүний эрхийн Үндэсний Комиссын гадаад хамтын ажиллагааны тасгийн дарга, Баярсайхан Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ эрх зүйн газрын атташе гэж байна. Сүхболд Гадаад харилцааны Гэрээ, эрх зүйн газрын дарга.

Мөнх-Оргил гишүүнийг танилцуулгаа хийхийг хүсэж байна.

Ц.Мөнх-Оргил: Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр 9 дүгээр тогтоолоор ийм ажлын хэсэг байгуулсан. Тэгээд ажлын хэсгийн зорилго нь бол олон улсын олон талт гэрээний хэрэгжилтийг Их Хурлаараа хэлэлцье гэж ярьсан юм. Тэгээд гол нь бид нар энийг хэлэлцчихээд, Байнгын хороонуудаар хэлэлцчихээд Улсын Их Хурлаас тогтоол гаргаад Засгийн газарт тодорхой үүрэг, даалгавар өгье гэсэн бодолтой байгаа юм. Ажлын дэд хэсэг байгуулагдсан. Энэ дээр манай 10 гаруй яамдын төлөөлөл, хуулийн мэргэжилтнүүд орж ажилласан. Тэгээд бид нар нийт 10 гаруй удаа хуралдчихаад байгаа юм. Тэгээд хурлынхаа ажлынхаа дүнг танилцуулж байгаа юм. Хууль зүйн байнгын хороонд 2021 оны 10 дугаар сарын 5-нд танилцуулчихсан. Нийгмийн бодлогын байнгын хороонд өнгөрсөн 7 хоногт танилцуулчихсан. Одоо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд танилцуулаад, энэ ажил үндсэндээ дуусаж байгаа юм.

Гишүүд ээ, энэ ийм ач холбогдолтой юм. Улс орнууд олон улсын гэрээг хүлээн зөвшөөрдөг 2 системтэй. Нэг нь монизм нөгөөдөх нь дуализм гээд. Манайх бол монизмтой байхгүй юу. Монизм гэдэг нь манай Үндсэн хуульд заачихсан байгаа шүү дээ. Монгол Улс олон улсын гэрээг соёрхон батлаад, Улсын Их Хурлаараа соёрхон

баталчихлаа шүү дээ. Тэгвэл яг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил шууд үйлчилж байгаа байхгүй юу. Шууд. Тэр хуулийг заавал Монголын хууль тогтоомжид үг үсгээр нь оруулаад, эсвэл тэр тусад нь хууль болгож батлаад байх шаардлагагүйгээр. Жишээ нь бид нар Парисын конвенцод нэгдээд л орчихсон л бол тэр Монголын хууль болчихож байгаа байхгүй юу. Саяын малын даатгалын хуультай адилхан. Тэгэхээр юу гэсэн үг вэ гэвэл яам, тамгын газар, шүүх, прокурор, бүх шатны Засаг дарга нар тэр хуулийг мэддэг, хэрэгжүүлдэг байх ёстой шаардлага тавигдаж байгаа байхгүй юу. Нөгөө нэг систем нь болохоор тэр гэрээ конвенцыг аваад, дотоодын хууль тогтоомж болгож, тусад нь хууль болгож баталж байж хэрэгжүүлдэг байхгүй юу. Манайх болохоор нэгдэж орлоо, соёрхон баталлаа, автомат Монголын хууль болж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар ийм чухал үүрэг хүлээчихсэн. Тэгээд Үндсэн хуульдаа Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлнэ гээд бүр маш том амлалт авчихсан ийм байгаа юм.

Дараагийнхыг нь гаргачих даа. Нийт Монгол Улс 294 олон улсын олон талт гэрээнд соёрхон баталсан байгаа. 294 том тоо байгаа биз. Энэ дээр 30 гэрээг тайлагнах ёстой юм. Энэ дотроо тайлагна гэдэг нь манайх энэ гэрээний заалтыг ингэж ингэж хэрэгжүүлж байна шүү гээд бусад нөгөө гэрээнд нэгдэж орсон улс орнууд, Нэгдсэн Үндэсний Байгууллага, Олон улсын байгууллагуудад тайлангаа явуулдаг Тайланд нь хариу ирдэг ийм юм байгаа юм.

Дараагийн слайдыг нь гаргачих. Энэ дээр байна шүү дээ Хүний эрхийн 18, Байгаль орчны 5, Гэмт хэрэгтэй тэмцэх 4, Эрүүл мэндийн 3 гээд 30 том хамгийн чухал 30 гэрээг нь бид нар судалж байгаа байхгүй юу. Энэ ажил үндсэндээ 3 жил хийгдэж байгаа юм. Дэд ажлын хэсэгт бараг 50 гаруй салбар, салбарын 50 гаруй

мэргэжилтнүүд оролцсон. Дараагийн слайдыг нь гаргачих. Өнгөөр нь ялгах юм бол улаан нь бол Хууль зүй, дотоод хэргийн яам, шар нь бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, улбагар шар нь, цэнхэр нь Эрүүл мэндийн яам, ногоон нь болохоор Байгаль орчны яам хариуцсан конвенцууд байгаа юм. Энэ 30 конвенцыг бүгдийг нь үзэхээр байна шүү дээ. Манайд ерөөсөө зөвхөн танайтай холбоотой 5 конвенц биш нийт 294 конвенц, тэр дундаа тайлагнадаг 30 конвенц дээр үндсэн 6, 7 асар том дутагдал байна. Тэрийг хэдүүлээ Засгийн газартайгаа нийлж ярьж байж засахгүй бол бид нар хууль тогтоомжоо ч сайжруулж чадахгүй олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ ч биелүүлж чадахгүй. Тэр хэмжээгээрээ энэ гэрээ конвенц хууль тогтоомж иргэдэд очиж үйлчлэх, тэдний амьдралд туслах, дэмжих, тэр эрхийг нь хамгаалах, үүргээ биелүүлэхэд нь туслах тэр үүргээ биелүүлж чадахгүй болчихоод байгаа байхгүй юу.

I дүгээрт төрийн байгууллагуудын хоорондын уялдаа зохицуулалт харилцан мэдээлэл солилцол хангалтгүй байна гэдэг. Энэ бол ерөөсөө хаа хаанаа л байгаа проблем. Бүгд л мэднэ шүү дээ бид нар. Гэхдээ энэ олон улсын гэрээ конвенц дээр бол бүр илүү. Яг манайх энэ чинь салбар хоорондын аягүй олон конвенцууд байгаа байхгүй юу. Жишээ нь Байгаль орчны яамны конвенц гэхэд л тэр хорт хаягдал, Хил дамнаж тээвэрлэх тухай конвенц гэхэд л тэр чинь Байгаль орчны орж байгаа, үйлдвэржилт орж байгаа, зам тээвэр орж байгаа юм. Орон нутгийн засаг захиргаанууд орж байж энэ конвенцын хэрэгжилт чинь хангагдаж байгаа байхгүй юу. Ийм хорттой бодисыг ингэж тээвэрлэнэ шүү. Ийм хорттой бодисыг улсдаа оруулахгүй шүү. Энийг гадагшаа гаргахгүй шүү. Энийг ингэж бие биедээ хэлнэ шүү гээд энэ мэдээлэл ерөөсөө хоорондоо солилцогдохгүй болохоор нэг газар хорттой бодис нь байгаад байдаг. Тэрийг яахаа мэддэггүй. Нөгөөдөх нь

тээвэрлэх ёстой хүн нь тээвэрлэх юм байхгүй. Би бэлэн байна, тээвэрлэх юм байхгүй жишээ нь. Ингээд л ерөөсөө мэдээлэл солилцоо дутагдалтай байгаа юм.

2-т ерөөсөө хамгийн том дутагдал бол манай Монгол Улсын шүүх олон улсын гэрээ конвенцуудыг шууд хэрэгжүүлж байх ёстой. Гэтэл шүүх дээр энэ мэдээлэл ерөөсөө очдоггүй. Шүүх нь байтугай хуулийг хэрэгжүүлээд сууж байгаа ажилтнууд бид нар хүртэл энийгээ яг ийм конвенцод орчихсон, энэ конвенцын цаана бид нар ийм үүрэг хүлээчихсэн, ийм торгуультай шүү, ингэж зохион байгуулах ёстой шүү гэдэг юмаа мэддэггүй. Тэгээд жишээ нь шүүх дээр бол ийм процесс байгаа байхгүй юу. Жишээ нь Монгол улс бол эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг олон улсын конвенц гээд асар том конвенц нэгдээд орчихсон. Тэр конвенцын зарим заалтууд нь Монгол Улсын хууль тогтоомжид орчихсон байгаа байхгүй юу. Иргэний хууль, Гэр бүлийн хууль, жендерийн хууль эд нарт орчихсон. Гэтэл нэлээн хэсэг заалт нь ерөөсөө хуульд тусгагдаагүй байж байгаа юм. Тэгтэл шүүгч яах ёстой вэ гэхээр энэ заалт маргаан шийдвэрлэж байна шүү дээ. Эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхсан уу, үгүй юу гээд асуудлыг шийдэх гээд сууж байтал үгүй ээ энэ чинь яг одоо манай хуулиар Хөдөлмөрийн хуулиар, Гэр бүлийн хуулиар, Иргэний хуулиар ялгаварлан гадуурхсан гэж хэлэхийн аргагүй юм байна гээд дуусчхаж байгаа юм. Гэтэл тэр шүүгч яах ёстой вэ гэхээр тэр эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг конвенцын заалтыг өөрөө мэдчихсэн, үзчихсэн, харчихсан. Тэгээд Монголын хуульд байхгүй ч гэсэн Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээ конвенцын энэ заалт байна. Тэгэхээр энэ заалтыг бариад би энэ асуудлыг ингэж шийднэ гээд шийдэж байх ёстой байхгүй юу. Энэ байхгүй. Энэ байгаль орчны юун дээр ч гэсэн ийм юмнууд зөндөө гарч байгаа юм. Жишээ нь Парисын конвенц гээд л нөгөө

протоколын хэрэгжилтийг хариуцаж байгаа юмнууд дээр байж байгаа юм.

3 дахь ерөөсөө нэг том бид нар нэг анхаарах ёстой зүйл бол төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтворгүй байдал. Нэг нөхөр очоод л саяын эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхахын эсрэг конвенцын тайлан гэж юм хийдэг юм. Жишээлбэл Женевт очоод л бид нар ингэж байгаа ингэж байгаа гээд л ийм юм чинь дутуу байна энийгээ ингэж зас гээд л тэгье тэгье гээд л ирээд л нөгөө юм юмаа хийж байтал солигдоод л өөр ажилд шилждэг. Эсвэл төрийн албанаас гарахад, дараагийн хүн нь ирдэг. Нөгөөдөө цоо шинээр эхлээд л ингээд жил, жил үргэлжлээд байгаад хэн нь юу хийж байгаагаа, өнгөрсөн нь юу хийж байгаагаа мэддэггүй, ямар амлалт авснаа ойлгодоггүй, юу хийх гэж байсан нь мэдэгддэггүй ингээд манай нийт төрийн албаны нэг л ийм том дутагдал байгаа юм.

Энэ олон улсын гэрээний хэрэгжилтийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй байгаа юм. Ямар конвенцод нэгдэж орсон нь Гадаад яаман дээр байгаад байгаа байхгүй юу. Бүгд байгаад байгаа. Англи, Монгол хэл дээр байж байгаа. Ямар үүрэг хүлээсэн нь байж байгаа. Яг яаж хэрэгжүүлж байна гэдэг дата бааз үүсэх ёстой. Тэр нь байдаггүй юм. Тэгээд энийг том ажлыг хэдүүлээ хийгээд Их Хурлаас тогтоол гаргаад, Засгийн газарт үүрэг, даалгавар өгөөд энэ дата баазыг байгуулья гэж байгаа юм. Жишээ нь яах ёстой вэ гэхээр саяын нөгөө эмэгтэйчүүдийн эсрэг конвенцынхоо жишээгээр авъя л даа. Тэрний 6 дугаар зүйл дээр ингэж ингэж заасан байна. Үүний хэрэгжилтийн энэ I дүгээр зүйлийг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцаад ийм ийм ажил хийж байгаа, ийм ийм дутагдал байгаа Энэ дээр ийм ийм хөрөнгө гаргасан, ийм ийм юм хийж байгаа гээд бүр нарийвчилсан дата бааз бий болгомоор байгаа юм.

Дараагийнх нь Эрүүл мэндийн яам хариуцаж байгаа. Эрүүл мэндийн яам ийм юм хийсэн. Тэгээд яам, Тамгын газар тэр дата бааз руу шууд ороод энэ яам ийм юм хийж байгаа юм. Энд бид нар ийм юм өгөх ёстой юм байна. Тэгээд бие биеийнхээ мэдээллийг аваад бие биедээ мэдээлэл солилцдог ийм дата бааз үүсгэхгүй бол ер нь болохгүй байна.

5 дахь ерөөсөө бидний хамгийн том дутагдлуудын нэг гэх юм бол ерөөсөө яг юунд элсэж орж байгаагаа бүрэн гүйцэд Засгийн газар ч тунгааж ойлгодоггүй. Засгийн газар дутуу тунгааж ойлгоод бид нарт өргөн барьсан юмыг Их Хурал үндсэндээ Засгийн газартаа итгээд л шууд соёрхон баталчхаад байна. Тэрийг ерөөсөө энэ чинь шууд Монгол Улсын хууль болж байгаа шүү гэдгийг ойлгоод, бид нар чинь хууль тогтоомжийн хуультай шүү дээ. Хууль тогтоомжийн хуулиар чинь хэдэн төгрөгийн зардал гарах юм, хүн хүч байна уу, бусад хуульд яаж үйлчлэх юм, Үндсэн хуультайгаа нийцэж байна уу, төрийн бус байгууллагуудын саналыг авсан уу гээд л бид нар Хууль тогтоомжийн хуулиар нэг хуулийн төсөл өргөн барих гэж өчнөөн цаас бүрдүүлж байгаа шүү дээ. Олон улсын гэрээн дээр тэгэх ёстой. Тэгэхдээ тэгдэггүй. Тэгээд өөрсдөө биелүүлж чадахгүй, яагаад ч биелүүлж чадахгүй юмандаа нэгдээд орчихдог. Энэ чинь их аюултай байгаа байхгүй юу. Нэгдэж биелүүлж чадахгүй бол бид нар нэгдэж орох ёсгүй л байхгүй юу. Тэрнээс биш одоо нэгдээд орчихъё тэгээд аажим аажмаар нөөцөө бүрдүүлээд, мөнгө төгрөгтэй болж байгаад 10 жилийн дараа хэдүүлээ конвенцоо хэрэгжүүлнэ гэж болохгүй шүү дээ. Хуулийг ч тэгж болохгүй. Одоо байгаа нөөц дээрээ л тааруулж бид нар хуулиа батална. Байгаа нөөцдөө тааруулж бид нар хэрэгжих бололцоотой юмаа л батлах ёстой шүү дээ. Тэгээд энэ дээр жишээ бол тоотой юм шиг байгаа байхгүй юу. Энэ чинь хамгийн тод жишээ гэхэд л Эрүүдэн

шүүх конвенцод нэгдээд орчхож байгаа юм. Тэгэнгүүтээ тэр конвенц юу гэж заадаг вэ гэхээр эрүүгийн гэмт хэрэг болгож яг ийм үг үсгээр Эрүүгийн хуульдаа суулгаарай гээд жишээ нь конвенц заачихсан бид нар тийм үүрэг хүлээчихсэн байхгүй юу. Тэгэнгүүтээ конвенцдоо нэгдэж орчхоод тэрнийхээ дараа 1, 2 сарын дараа ч юм уу нөгөө эрүүгийн хуулиа янзалж эхэлж байгаа юм. Тэр чинь 1 дүгээрт зөрчихөж байгаа юм. 2 дугаарт нөгөө тэр конвенцыг хэрэгжүүлж байх ёстой төрийн албан хаагчид ямар ч мэдээлэлгүй сууж байгаа байхгүй юу. Тэр чинь нэгдэж орохынхоо өмнө цагдаа, прокурор, шийдвэр гүйцэтгэлийн ажилтнууд, төрийн захиргааны албан хаагчдад энийг эрүүдэн шүүлт гэнэ шүү, чи нөхөр минь ийм юм хийчихвэл эрүүдэн шүүх нь байна шүү гэж хэлж, тайлбарлаж, ойлгуулчихаад бүгдээрээ бэлэн болчихоод Эрүүгийн хуульдаа ийм өөрчлөлт оруулна гэдгээ тохирчихоод конвенцод орж баймаар байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол сая жишээ нь тэр эрүүдэн шүүх дээр ямар жишээ гарч байна вэ гэхээр ийм юм болж байгаа юм. Тэр конвенцоор төрийн албан хаагч, албан тушаалтан бусдыг эрүүдэн шүүж болохгүй гэж байгаа юм 1 дүгээрт. 2 дугаарт төрийн албан хаагч бусдаар өөрийнхөө эрхшээлд байгаа төрийн албан хаагч биш хүмүүсийг даалгавар өгч эрүүдэн шүүлгэх юм бол тэр шүүсэн хүн ч эрүүгийн хариуцлага хүлээнэ. Тэрнээс илүү өндөр хариуцлагыг тэр араас нь шөвөгдөж явуулсан төрийн албан хаагч нь хүлээх ёстой байхгүй юу. Конвенцоороо Гэтэл манай Эрүүгийн хуульд нөгөө сая эрүүдэн шүүсэн гээд л нэг бөөн асуудал болсон шүү дээ. Тэр дээр яасан гэхээр манай төрийн албан хаагч чинь тэрийг мэддэг, манай нөгөө Эрүүгийн хуульд тэр конвенцын заалт нь зөвхөн төрийн албан хаагчаар орчихсон учраас өөрөө эрүүдэн шүүдэггүй хүнээр очоод эрүүдэн шүүлгэчихдэг. Өөр нэг ялтнаар очоод нөгөө ялтнаа баахан эрүүдэн шүүлгэчихдэг. Тэгээд яг хуулийг нь хэрэгжүүлэх гэхээр би биш шүү дээ

гээд гэх мэтийн ийм олон олон зөрчлүүд маш их гараад байгаа. Тэгэхээр энийг хэдүүлээ бүгдийг нь ингэж яг юу өөрчлөх гээд байгаа юм. Ямар үр дагавар гарах юм. Хэдэн төгрөг болох юм. Тийм санхүүгийн бололцоо байна уу, үгүй юу гэдгийг нь үзэж байж хийж баймаар байгаа юм.

Бид нар Их Хуралд нэг том дутагдал байна. Баахан конвенц баталчихдаг. Тэгээд тэр конвенцынхоо хэрэгжилтийг ерөөсөө хойноос нь хөөдөггүй. Одоо жишээ нь танай Байнгын хороо бол Нийгмийн бодлогын байнгын хороо байна шүү дээ 18 маш том гэрээ конвенцын хэрэгжилтийг 1 ч удаа хэлэлцээгүй байгаа. Танай Байнгын хороо 5 том конвенцын хэрэгжилтийг хангаж байх ёстой. Танайх 1 ч удаа хэлэлцээгүй. Яаж байна вэ гэхээр очоод нөгөө эрүүдэн шүүх ч байдаг юм уу, хүнийг хүчээр алга болгох ч байдаг юм уу, Парисын конвенцын хэрэгжилт ийм байна гээд баахан тайлагначихдаг. Тэр тайлан нь яамандаа хавтсандаа үлдчихэж байгаа юм. Жишээ нь эдний яамны хавтсанд бол тэр зөндөө тайлан байгаа байхгүй юу. Тэр нь яг хэрэгжсэн юм уу, хэрэгжээгүй юм уу гэдгийг Засгийн газар нь ч сонсдоггүй, Их Хурал нь ч сонсдоггүй. Тэгэхээр бид нар ямар журамд шилжих эрхтэй байна вэ гэхээр жилдээ 1 удаа жишээ нь энэ яамнуудаар конвенц болгоноор нь тайланг нь тавиулж баймаар байгаа юм. Тэгээд өмнөх жил ингэсэн шүү, одоо энэ жил ингэчихсэн байна. Одоо энийгээ хий, энэ дээр чинь хариуцлага тооцлоо гэж ингэж шахааж ажиллах хэрэгтэй байгаа юм.

Төрийн бус байгууллагуудыг үндсэндээ нэг их оролцуулахгүй, тэгээд л яамдууд бие биеэсээ хэдэн санал аваад л хийчхээж байгаа юм. Энэ дээр төрийн бус байгууллага дээр бол арай гайгүй идэвхтэй ажилладаг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөгөө нэг том шүхэр байгууллага байлаа. Тэр идэвхтэй юм байна лээ. Бусад нь бол тэгээд л нэг.

Үйлдвэрчний эвлэл бол хариуцлагатай орж байгаа юм.

Олон улсын гэрээний хэрэглээ хангалтгүй байгаагийн нэг том шалтгаан нь ерөөсөө Монгол текстүүд нь ойлгогдохгүй байгаа юм. Яг мэргэжлийн хүн бүр ингэж нөгөө Англи Монголтой нь тулгаж байж, аан ингэж байгаа юм байна гээд. Тэгээд энэ юунаас шалтгаалаад байна вэ гэвэл нэр томъёог нь жигдлэхгүй байна. 2 дугаарт нэг газраар нэг гараар бүх орчуулгыг жигдэлж янзлахгүй болохлоор эдний яам жишээ нь 5 конвенцоо 5 өөр хүнээр орчуулуулчихад л яг адилхан нэр томъёо өөр газар өөр өөр үг хэллэгээр хэрэглээд л явчихдаг. Тэгээд тэрийг чинь хэрэгжүүлэх бололцоогүй болчихоод байгаа юм.

Тэгээд эцэст нь бид нар конвенцод нэгдэж орсон л бол дотоодынхоо хууль тогтоомжийг яг тэрэнтэй нь уялдуулж байх ёстой байгаа байхгүй юу. Жишээ нь Засгийн газрын тогтоол, журам. Үндсэн хуультай Монгол Улсын хууль тогтоомж нийцэж байхтай адилхан олон улсын гэрээ конвенцтойгоо нийцэж байх ёстой юм байгаа юм. Тэгээд танай Байгаль орчны яамтай холбоотой, танай Байнгын хороотой холбоотой ийм хэд хэдэн чухал юм байгаа юм. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц. Энэ нөгөө Киотогийн протокол Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын Парисын хэлэлцээр гээд. Үүгээр бид нар чинь нөгөө хүлэмжийн хийг хэдэн хувиар бууруулах ёстой билээ. 20230 он хүртэл 22,7 хувиар бууруулах ёстой байгаа юм. Одоо хэдэн хувьтай бууруулчихаад байна. Тэгэхлээр энийг бол жишээ нь манай Байнгын хороо, танай Байнгын хороо байнга хяналтдаа байлгаж, болдог бол бүр конвенцуудаар тус тусад нь жижиж хэн ажлын хэсгүүдтэй, эд нартай байнга ажиллаж баймаар байгаа байхгүй юу. Яагаад гэвэл тэр нөгөө хүлэмжийн хийг 22,7 хувиар бууруулна гэдэг чинь асар өндөр амлалт. Тэрийг бууруулна гэдэг

чинь бид нар нүүрснийхээ хэрэглээг багасгах ёстой болно. Цахилгаан машинуудаа нэмэх хэрэгтэй болно. Нийтийн тээврээ цахилгаанжуулах хэрэгтэй болно гээд л маш олон салбарыг хамарсан салбар дундын хамтын ажиллагаа хэрэгтэй болчихоод байгаа байхгүй юу. Энэ чинь зөвхөн байгаль орчны асуудал биш шүү дээ. Энэ чинь хөдөө аж ахуйтай холбоотой, уул уурхайтай холбоотой, зам тээвэртэй холбоотой гээд. Энийг та хэд нэг байнга харж баймаар байгаа юм. Тэгээд яам нь бол ганцаараа дийлэхгүй л дээ. Их Хуралтайгаа хамтарч л ажиллахгүй бол.

Дараагийн том конвенц нь биологийн олон янз байдлын тухай конвенц гээд convention on biodiversity гээд байгаа юм. Энэ их чухал байгаа юм. Манайд их хаягдчихаад бид нар нэг их анхаарал тавихгүй байгаа аюултай юм бол аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай базелийн конвенц гээд. Ялангуяа 2 их хөршийн хооронд Монгол транзит болж байна. Зам тээвэр явж байна. Төмөр зам ачаа тээвэр нэмэгдэж байгаа үед аюултай хог хаягдал хил дамнасан тээврийн асуудал чинь байнгын хяналтад байж байхгүй бол бид нар чинь гаднаас өчнөөн л бараа бүтээгдэхүүн оруулж ирж байна шүү дээ. Наад зах нь л бид нар нөгөө тэр приусийн батареиг л яах вэ аккумуляторыг яах вэ гээд л. Энэ чинь л өөрөө бас л аюултай хог хаягдлын тоонд л орж байгаа байхгүй. Энийгээ хармаар байгаа юм.

Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээж зөвшилцөх журмын тухай ротердамын конвенц гээд. Энэ бол манай хөдөө аж ахуйн бүр газар тариалангийн салбарт бүр байнга үзэж байх ёстой, хэмжиж байх ёстой маш чухал конвенц байгаа байхгүй юу. Энэ чинь ямар пестицид хэрэглэж болох вэ, ямрыг нь хэрэглэж болохгүй вэ гэдгийг заагаад өгчихсөн. Бид нар чинь энийг хэрэглэнэ,

энийг импортлоно, энийг экспортолно, энийг оруулахгүй гээд амлалт хүлээчихсэн байж байгаа шүү дээ. Гэтэл энийг яг хил дээр хянаад, хэрэгжүүлээд, лабораториуд нь байна уу, үгүй юу. Ямар үр дүнтэй байна. Энэ чинь хориглочихсон пестицидээр орж ирээд байгаль орчин, газар тариаландаа хэрэглээд явах юм бол ямар үр дагавар гарах вэ. Тийм ээ. Энэ айхтар хорт хавдрын чинь суурь нь ер нь хүнс, хүнсний чинь суурь дээр энэ байж байх л юм бол тэгээд л бид нар яаж ч эрүүл мэндээ хэдэн ч эмнэлэг бариад нэмэргүй л асуудал болчихно шүү дээ. Тэгэхээр суурь нь энд байгаа юм. II

Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокольмын конвенц, Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц гээд. Манайд бас холбоотой. Нинжа, уул уурхай чинь мөнгөн усны асуудал чинь асар их болчихоод байна шүү дээ.

Дээр нь цөлжилтийн конвенц байгаа. 2026 онд манайх чинь цөлжилтийн конвенцод нэгдэж орсон улс орнуудын 17 дахь уулзалтыг зохион байгуулах гэж байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр бид нар яг хүлээсэн үүргээ биелүүлж байна уу. Юу хийж байна гэдгийг нэг үзмээр байгаа юм. Рамсарын конвенц гэж байгаа юм. Эд нар ч бол яах вэ л Халим агнуур, зэрлэг амьтны нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенц гээд.

Тэгээд хамгийн сүүлд нь озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Венийн конвенц гээд. Засгийн газар эд нарт энэ 5 конвенцыг хариуцуулжээ. Нөгөө мэдээлэл өгдөг, хариу өгдөг. Аюултай хог хаягдлын конвенц, Удаан задардаг конвенц, Органик бохирдуулагчийн конвенц, Амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Мөнгөн усны конвенц гээд. Эд нар бол яах вэ би бол эд нарыг нөгөө яг конвенцод тайлбарлаад биш гол нь яг ямар проблемууд юун дээр анхаарах

хэрэгтэй байна гэдэг дээр л юмнуудаа бэлд гэсэн юм. Тэгээд энэ дээр яг проблем асуудал, танай Байнгын хороогоор шийдүүлэх, Улсын Их Хурлаар шийдүүлэх, Засгийн газарт санал өгөх юмнууд дээр 2, 3 юм хэлчихье.

Яам эргээд бид нарт үүрэг даалгавар өгчхөж байгаа юм. Хуулиа шинэчил, эсвэл энэ төлөвлөгөөг хэрэгжүүл гээд л. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч гэсэн тэгж байгаа юм. Засгийн газар, Улсын Их Хуралдаа баахан үүрэг өгчихдөг байхгүй юу. Одоо ингээд л эд нар бас л бид нарт баахан үүрэг өгчхөж байгаа юм. Тэгээд энэ дээр би уг нь та нартай нөгөө дэд ажлын хэсэг дээр хэлсэндээ. Энд маш товчхон давтаад хэлчихье. Энийгээ бол хэдүүлээ өнөөдөр Байнгын хороон дээр бол энд зөвлөмжүүдээ гаргачихсан уу. Цаашид авах арга хэмжээний тухай. Өнөөдөр ингээд Байнгын хороон дээр хэлэлцээд ярьчихъя. Одоо энэнтэй чинь холбогдуулаад Их Хурлаар тогтоол гарна шүү дээ. Тэр тогтоол дээр бол эргээд хэдүүлээ Их Хуралдаа үүрэг даалгавар өгөөд байхгүй. Та нар жишээ нь ингэчихсэн байна шүү дээ. Засгийн газрын холбогдох тогтоолуудад шинээр батлагдсан бодит бүтээгдэхүүнийг нэмэх гээд ийм юм орохгүй шүү дээ. Засгийн газрын Улсын Их Хурлын тогтоол дээр бол яг ямар бодисыг яриад байгаа юм. Ямар бүтээгдэхүүнийг яриад байгаа юм. Ямар үндэслэлээр нэмэх гээд байгаа юм. Аль тогтоол дээр нэмэх гээд байгаа юм гэдгийг нь бүгдийг нь дэлгэрэнгүй тусгаж Их Хурлын тогтоолынхоо төсөл дээр тусгана шүү дээ. Тэрийгээ мэдэж байгаа тийм ээ. Хөтөлбөр хэрэгжүүлэх ч гэх шиг. Тэгээд ямар төсөл хэрэгжүүлэх гээд байгаа юм. Тэрийгээ сайн хэлнэ биз дээ. Ингээд 5 конвенцын материалыг би бүгдэд нь дэлгэрэнгүй Улсын Их Хурлын гишүүдэд тараачихсан учраас нийтлэг авах арга хэмжээний тухай саналуудыг нь танилцуулчихъя. Гишүүд энэ 5 конвенцынхоо юмнуудыг өөрсдөө нэг мөр

танилчихаарай. Тэгээд асуулт байвал хариулъя.

1 дүгээрт хүчингүй болсон үндэсний хөтөлбөрүүд байгаа юм. Нөгөө яачихсан гэхээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлаад тэгээд үндэсний хөтөлбөрүүдийг 2021 онд хүчингүй болгочихсон байхгүй юу. Гэтэл саяын нөгөө Минаматагийн конвенц, Парисын конвенц эд нар чинь бүгд заавал үндэсний хөтөлбөртэй байх ёстой. Бид нар нөгөө үүрэг хүлээхдээ үндэсний хөтөлбөр батална. Үндэсний хөтөлбөрөө ингэж хэрэгжүүлнэ гэсэн үүрэгтэй. Үндэсний хөтөлбөрөөр жишээ нь хүлэмжийн хийг 22,7 хувиар 2050 он гэхэд бууруулна гэдэг чинь Үндэсний хөтөлбөртөө тусгаж байх ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ үндэсний хөтөлбөрүүдийг эсвэл Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулаад Их Хурлаараа батлуулах хэрэгтэй байна. Эсвэл та нар Засгийн газраараа оруулаад энийгээ хурдан батлуулах хэрэгтэй байна. Салбар дундын конвенцын асуудлыг нэг яримаар байна. Ялангуяа энэ байна шүү дээ. Танай Байнгын хороон дээр танай ч юу байх вэ манай Байнгын хороо дээр хэлэлцэгдэж байгаа конвенцууд дээр хамгийн их байгаа юм. Жишээ нь Хууль зүйн байнгын хороо дээр байгаа конвенцууд гэхэд Улс төрийн эрхийн факт, Эдийн засаг, нийгэм, соёлын, эрх зүйн факт гэхээр дандаа нөгөө хууль тогтоомж, шүүх, прокурортой холбоотой заалтууд учраас тэр бол салбар дундын юм их багатай. Нийгмийн чиглэлийн юмнууд гэхээр эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах ч байдаг юм уу, хүүхдийн эрхийн конвенц тэр гэхээр тэнд бас салбар дунд ийм харьцангуй багатай байхгүй юу. Яг энэ Байнгын хороонд харьяалагдаж байгаа жишээ нь аюултай хог хаягдлын хил дамнасан худалдаа ч гэдэг юм уу, мөнгөн усны юу гэдэг чинь гааль, хил, импорт, экспорт, үйлдвэрлэл, уул уурхай, тээвэр гээд маш олон салбаруудыг хамардаг салбар хоорондын юм байгаа байхгүй юу.

Тэгэхээр танай дээр энэ асуудал дээрээ конвенц болгоноор нь ажлын хэсэг гарга, ядаж энэ конвенцын энэ нь хэрэгжээд, тэр яам энийгээ хэрэгжүүлэхгүй байна гэдэг баримжаатай байж байж шахах ёстой юм байна лээ. Тэгээд Засгийн газар бол хууль хэрэгжүүлнэ л дээ. Тэгэхдээ Засгийн газрын хууль хэрэгжүүлж байгаа эсэхийг бид нар шалгаж байх ёстой шүү дээ. Тэр хүрээндээ л та нар энийгээ хэрэгжүүлэхгүй байна, энийг хэрэгжүүлэхгүй байна Их Хурлаас ийм үүрэг даалгавар өгөөд байхад хэрэгжүүлэхгүй байна гэж бид нар шахахгүй бол Засгийн газар нөгөө өдөр тутмынхаа ажилдаа баригдаад л явна. Их Хурлын үүрэг бол энэ хуулийн заалт ингэж хэрэгжсэн байна, энэ дутуу байна. Энийгээ ингэж хэрэгжүүл. Конвенцын заалтыг бас ярьж байх ёстой юм байгаа юм.

Тэгээд нийтлэг бид нар ямар дүгнэлт хийх гэж байгаа вэ гэхээр Улсын Их Хурлаас тогтоол батална. Тогтоол дээрээ конвенцын заалт бүрээр нь энийг ингэж ингэж зас. Энэ конвенцыг ингэж хэрэгжүүл. Ийм ийм арга хэмжээ ав. Энэ хуулийг ингэж зас гэсэн тийм нэлээн зузаан бараг 2 хуруу шахуу тийм том тогтоол батлагдана. Тэгээд манай Их Хурлын 3 жилийн ажил энүүгээрээ цэглэгдэнэ. Тэгэхдээ дуусчихгүй. Энийгээ байнга л хянаад байх ёстой юм байгаа юм. Жилдээ нэг удаа л та нар конвенцуудаа хэлэлцээд байх ёстой юм байгаа юм шүү. Баярлалаа.

Б.Саранчимэг: Баярлалаа.

Тэгэхээр өнөөдөр бид нар маш чухал асуудлыг хэлэлцэж байна. Тэгээд өнөөдөр бас яг ажлын хэсэг гараад, ажлын хэсгийн ахлагч Мөнх-Оргил гишүүн маш чухал асуудлыг хөндөж танилцуулга хийлээ. Тэгэхээр ер нь бол Улсын Их Хурлын гол үүрэг бол хуулийн төслөө батлах, батлагдсан хууль, тогтоомж бид нар хяналтаа тавих гол үндсэн үүрэгтэй. Тэгэхээр цаашидаа бид нар яг энэ гэрээ конвенц дээр ч гэсэн яг жилдээ 1 удаа хэрэгжилтийг нь танилцаад, яг

хэрэгжиж байна уу, үгүй юу. Үнэхээр хэрэгжээгүй бол бид нар хариуцлагаа тавих зайлшгүй шаардлагатай байгаа юм. Тэгэхгүйгээр нэг танилцуулчихдаг, танин мэдэхүйн мэдээлэл өгөөд явуулчихдаг яамдууд. Тэгээд Улсын Их Хурал дээр танилцсан болоод, ганц гэрээ конвенц ч биш ер нь цаашидын хурал дээр ч гэсэн манай яамнууд цаашаа бүр сайн анхаараарай. Мэдээллүүдээ өгөхдөө бас удааширалтай яг энэ тал дээр бас анхаарах хэрэгтэй л байгаа юм.

Тэгэхээр өнөөдрийн танилцуулсан танилцуулгатай холбогдуулаад асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Өнөрболор гишүүнээр тасаллаа. Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Мэдээллийг сонслоо. Тэгэхээр Монгол Улс бол НҮБ-ын бас янз бүрийн олон конвенцуудад нэгдэн орж байна л даа. Зөвхөн байгаль орчны салбарт ч биш. Олон салбарт нэгдэж орж байна. Мөнх-Оргил гишүүний саяын хэлж байгаагаар жаахан ойлголт муу байна л даа. Нэгэнт конвенцод нэгдэн орсон бол бид нар хууль батлах шаардлагагүй ингээд хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой юм байна. Үүний дагуу тухайн конвенцын дагуу Үндэсний хөтөлбөр батлах ёстой юм байна гэж ингэж ойлголоо. Тэгэхээр байгаль орчны чиглэлээр манайх энэ конвенцуудад ер нь Үндэсний хөтөлбөр батлагдаагүй ийм нэгдэж орсон конвенц байгаа юм уу. Эсвэл Үндэсний хөтөлбөрүүд нь хэр үр дүнтэй хэрэгжиж байгаа вэ. Үүний дагуу бид нар тайлангаа өгдөг юм байна гэж ойлголоо. Тайлангаа өгөөд тайлан өгсний дараа ер нь Монгол Улс байгаль орчны чиглэлээр нэгдэн орсон конвенцууддаа өөрийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй. Ийм ямар конвенцууд байнаб Тэгэхээр энэ чиглэлээр бол би ингэж бодоод байна л даа. Ер нь биелүүлээгүй тохиолдолд ер нь яадаг юм. Жишээлэх юм бол Монгол Улс конвенцод нэгдэн орчхоод, тэгээд өөрсдийн хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд ер нь ямар хариуцлага хүлээдэг юм бэ.

Тэгэхээр энэ хүрээнд бид нар яах вэ, бас зарим нэг тохиолдолд юу гэдэг юм уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчны чиглэлийнх бол дандаа химийн хортой бодисын ч гэдэг юм уу, ховордсон ан амьтдын энэ тэр гээд зүйлүүд байна л даа. Тэгэхээр ховордсон ан амьтдын чиглэлээр олон улсын конвенцод нэгдэн орсноороо манай өөрийн дотоодод хийгдэж байгаа хуулиас зөрүүтэй зүйл юу байгаа юм. Жишээлэх юм бол тайлан дээр бичсэн байна л даа. Аргаль угалз агнуулах асуудлууд гардаг шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр манай зөвшөөрлөөр ан агнуурын асуудал нь яг конвенцтой зөрчилдөж байгаа зүйлүүд байна уу. Үүнээсээ болоод бас магадгүй конвенцоосоо буцаж гарах ийм шаардлагатай ч гэдэг юм уу, ийм зүйлүүд байгаа юу гэдгийг би зүгээр эхлээд асуугаадахъя. Тэгээд хариулт авч байгаад тодруулъя.

Б.Саранчимэг: 2 номер хариулъя. 2 номерын микрофоныг өгье дөө. Битгий дар дарахгүй шүү дээ. 2 номер ажиглахгүй байгаа бол 3 номерын микрофоныг өгье дөө.

Д.Ариунтуяа: Асуултад хариулъя. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн Олон талт хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ариунтуяа байна. Монгол Улс байгаль орчны салбарт 12 конвенц, 5 протокол, 1 бие даасан хэлэлцээрт нэгдэж орсон байгаа. Энэ бүртгэлээр манай Байгаль орчин, аялал жуулчлалын яам хэрэгжилтийг хангах, уялдааг зохицуулах ажлыг бол хийж байгаа юм. Энэ конвенцуудын хувьд бол конвенцын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд бол манай яам үндэсний зохицуулагч томилж ажиллуулдаг. Дээрээс нь үндэсний зохицуулагчаас гадна, конвенцыг хэрэгжилтийг хангаж ажиллах салбар дундын зохицуулалтыг хийх үүрэг бүхий конвенцын хэрэгжилтийг удирдан зохицуулах зөвлөл гэдгийг бол байгуулж ажилладаг байгаа. Таны асуусан үндэсний хөтөлбөрүүдийн

хувьд бол конвенц болгон тусдаа. Байгаль орчны салбарт нэгдэж орсон 6 конвенц яг өөрийнхөө нөгөө эх текст дээрээ тухайн Засгийн нэгдэж орсон тал буюу Засгийн газрын үндэсний хэмжээний үндэсний хөтөлбөртэй байхыг шаардсан байгаа. Тэр 6 конвенц нь Риогийн 3 конвенц буюу уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал, цөлжилттэй тэмцэх гэдэг 3 конвенц. Тэгээд Мөнгөн усны конвенц. Мөнгөн усны конвенц маань 2 үндэсний хөтөлбөртэй байна гээд бүр эх текст дээрээ заачихсан байдаг. Тэгээд удаан задардаг органик бохирдуулагч буюу Стокхолмын конвенц үндэсний хөтөлбөртэй байна гээд. Үндэсний хөтөлбөрүүдийг бол манай яам тухай бүр нь нэгдэж орсныхоо дараа Үндэсний хөтөлбөрүүдээ үе шаттайгаар бол батлаад, хэрэгжилтийн тайланг нь бол хангаад Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт бас мэдээллүүдээ явуулдаг байгаа. Түрүүн Мөнх-Оргил гишүүний дурдсанчлан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар бол энэ конвенцуудын манай хүлээсэн үүргийн үндэсний хөтөлбөрүүд бол хүчингүй болчихсон байгаа. Тэгээд энэ маань Үндэсний хөтөлбөр хүчингүй болно гэдэг маань манай салбарт ялангуяа конвенцуудын хэрэгжилтийг хангаж ажиллахад бол маш их хүндрэлтэй болгож байгаа. Үндэсний хөтөлбөртэй байхын нэг давуу тал нь юу байдаг вэ гэхээр улс орнууд Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн түншлэгч талуудтайгаа, донор орнуудтайгаа үндэсний хөтөлбөрөө хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудлыг ярьдаг. Манай Байгаль орчин, аялал жуулчлалын яам дээр хэрэгжиж байгаа 20 гаруй төсөл бүгдээрээ байгаль орчны гэрээ конвенцуудын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх гэсэн зорилготойгоор хэрэгждэг тийм төслүүд бол байдаг аа. Хэрвээ конвенцыг хэрэгжүүлэхгүй бол, Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхгүй бол яах вэ гэх юм бол Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлээгүй гэдэг утгаараа гадаад

талдаа бол маш муу нэр хүндтэй болно. Гадаад талдаа муу нэр хүндтэй болно гэдэг маань салбарт оруулж ирэх төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын хэмжээ багасна гэсэн үг. Гэрээ конвенцоор хүлээсэн үүрэг, үүргийн биелэлт, хэрэгжилтийн тайланг цаг тухайд нь явуулахгүй байна гэвэл дараа дараагийн удаагийн түрүүний хэлсэнтэй адилхан шалтгаанаар дараагийн удаагийн хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламж, техникийн туслалцааны бүх л төсөл хөтөлбөрүүд зогсох тийм аюултай. Тэгэхээр бол манай яам харьцангуй гэрээ конвенцынхоо хэрэгжилтийг цаг тухайд нь.../минут дуусав/

Б.Саранчимэг: Өнөрболор гишүүн асуултаа асууя.

Д.Өнөрболор: Мөнх-Оргил гишүүний бас мэдээлж байгаа асуудал маш чухал асуудал орж ирж байна. Хууль тогтоомжоо хэрэгжүүлж чадахгүй байгаагаас олон улсын конвенцоор хүлээсэн үүргийн хэрэгжилт муу байгаа гэдэгтэй үнэхээр санал нэг байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол миний хувьд сая сүүлийн гээд л аваад үзэхэд орж ирсэн хууль, тогтоомжууд дотор Мөнх-Оргил гишүүнээс би асуухад Эрчим хүчний яамнаас оруулж ирсэн аж ахуйн нэгжийн орлогын татварт бол хөнгөлөлт үзүүлэх ийм хууль орж ирсэн байж байгаа. Тэгээд энэ нь болохоор яаж байна гэхээр цахилгаан, эрчим хүчний 5мвт-аас-аас дээш хүчин чадалтай, эсвэл дулааны эрчим хүчний 1,5мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэрийг үндсэн болон туслах тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэсэн тохиолдолд энийг ноогдох албан татварыг 90 хувь хөнгөлнө гэж байгаа юм. Тэгээд миний харж байгаагаар тэгээд би сайдаас асуухаар үндсэндээ шууд нүүрс түлэхийг, дээрээс нь Монгол Улсад өнөөдөр бараг 200, 300-аад яндан байгаа. Үүнийг үргэлжлүүлээд ашиглах ийм нөхцөл байдалтай байгаа, яалт ч үгүй үүнээс өөр шийдэл байхгүй гэсэн ийм тайлбартай байж байна гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр би энийг

үндсэндээ энэ асуудлын хувьд бол дэмжихгүй байгаа юм. Тэгээд өнөөг хүртэл нөгөө Парисын хэлэлцээрт чинь бид нар 2015 он байх элсэж ордог чинь. Тэгэхээр үндэсний хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд бол 22,7 хувь бууруулах зорилтыг тодорхойлсон байж байгаа. Тэгээд 7 жил болчихсон байж байна. Тэгэхэд өнөөдөр бид нар хэр зэрэг хэмжээгээр бууруулсан байна гэдгийгээ ч тодорхойлоогүй ийм хариуцлагагүй нөхцөл байдалтай байж байгаа. Тэгээд даруй 7 жил л үлдсэн байна. Тэгэхээр энэ хугацаанд бас юу хийгдэх юм бэ. Энэ амлалтууд чинь яаж хэрэгжих юм бэ. Тэгэхэд чинь энийг тодорхой мэдсээр байж байж мэдээж яах вэ шинэ сэргэлтийн бодлогын хувьд би том том Таван толгойн ч байдаг юм уу, эсвэл Бөөрөлжүүт Багануурын ч байдаг юм уу төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг миний хувьд бол дэмжиж байгаа боловч яг амьдрал дээр өнөөдөр Улаанбаатар хотод агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Үндэсний хорооны сүүлийн 10 жилд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа үндсэндээ ухрах ийм эрчим хүчний бодлого явагдаж байна гэдэг дээр санал нийлэхгүй, бие энийг дэмжихгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд ийм тохиолдолд яах ёстой вэ. Одоо энэ чинь сайд болон тэр яамны бүрэлдэхүүн чинь нийт 3 сая ард иргэдийн, тэр дундаа хотод амьдарч байгаа 2 сая ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, дээрээс нь олон улсын гэрээ хэлэлцээр конвенцын амлалтын эсрэг ухарсан ийм бодлого баримталж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр хэн хариуцлага хүлээж, ямар асуудал ярих ёстой юм бэ. Энэ дээр тодорхой шийдэл гаргаж, энэ асуудлыг бас байр суурийг нь өөрчлөх шаардлагатай байна. Ер нь дэлхийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг маш их олон нэмэгдүүлэх арга замууд байна шүү дээ. New zero-той холбоотой эко санхүүжилтүүдээс өгсүүлээд л дэвшилтэт технологийн маш олон арга хэлбэрүүд байхад чинь бид нар өнөөдөр нүүрснээсээ салж чадахгүй байгаа энэ нөхцөл байдал чинь маш олон хүмүүсийн

эрүүл мэнд, аюулгүй байдлыг заналхийлсэн ийм л бодлого явагдаж байна шүү дээ. Энэ дээр би хариулт авмаар байна. Ямар ямар юмнууд.

Нөгөөтээгүүр бас нэг асуудал нь миний цаг арай хүрэлцэхгүй юм шиг байна л даа. Бас нэг асуудал би нөгөө худалдааг дэмжих хуулийн төслийг бол боловсруулах ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар миний бие бол ахлаад явж байгаа. Тэгээд Дэлхийн худалдааны байгууллагад манай Монгол Улс аль дээр үед элссэн. Тэгээд худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт ч гэсэн бид нар 2015 онд байна уу даа, 2015 онд.../минут дуусав.

Б.Саранчимэг: Эхлээд Мөнх-Оргил гишүүнээс асуусан. Мөнх-Оргил гишүүн хариулъя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Яг тэр конвенцын нарийн ширийн юмнуудыг нь манай ажлын хэсгийнхэн хариулчихна биз. Зүгээр миний ойлгосноор бол бид нар огт нүүрс түлэхгүй гэж амлалт хүлээгээгүй л дээ. Ер нь бол 22,7 хувиар бууруулна гэж байгаа юм. Гэхдээ бууруулна гэдэг маань янз янзын аргаар л бууруулж болно шүү дээ. Тэгээд яг тэрийгээ хэрэгжүүлж байна уу, үгүй юү гэдгээ л манайхан хэлэх хэрэгтэй байгаа юм. Тэгээд улс болгон өөрийнхөө нөхцөл онцлог байдалд таарсан л арга хэмжээ авна л даа. Манай Монголын өнөөгийн нөхцөлд бол нүүрснээс өөр эх үүсвэр байхгүй л дээ. Ховор. Үүний цаана гишүүд ээ, ийм юм байгаа. Ялангуяа хүний эрх, байгаль орчны хамгаалах, цаг уурын өөрчлөлттэй холбоотой гэрээ конвенцуудын нэг чухал зүйл нь нөгөө манай улсын бусад олон талт хамтын ажиллагаа, Дэлхийн банк, Валютын сан ч гэдэг юм уу тэр олон талт санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа хамтын ажиллагааны үндсэн нөхцөл нь бол энэ суурь конвенцууд болчихоод байгаа байхгүй юу. Энэ конвенцоо хэрэгжүүлээгүй, үүнийхээ заалтыг биелүүлээгүй бол жишээ нь бид

нар ийм хөнгөлөлт өгөхгүй, танайхтай ийм зээл олгохгүй ч гэдэг юм уу. Жишээ нь дэлхийд бол нүүрс түлж эрчим хүч гаргаж байгаа аж ахуйн нэгж төслүүдэд бол жишээ нь зээл олгогдохоо л байчихлаа шүү дээ. Бид нар 22,7 хувьдаа хүрэхгүй байх юм бол жишээ нь тэр төслүүд эрсдэлд орно л гэсэн үг 1 дүгээрт.

2 дугаарт энийг чинь бид нар нөгөө өөр хүмүүст юм уу хэн нэгэн хүнд таалагдах гэж юм уу, хэн нэгэн хүнээс мөнгө авах гэж хийгээд байгаа юм биш шүү дээ. Энийг чинь бид нар хойч ирээдүйдээ бас хүн амьдрах хорвоо ертөнц үлдээх гээд л хийгээд байгаа шүү дээ. Үр хүүхдүүд маань, үр хүүхдүүдийн үр хүүхдүүд маань бас амьдарчихдаг, амьсгалдаг агаартай, нэг гайгүй хорвоо ертөнц үлдээхийн төлөө л хүн төрөлхтөн бүгдээрээ л чармайх дэрхийхээрээ хийж байгаа юм.

3-д нь энэ дээр нэг юм байгаа юм. Жишээ нь зарим орнууд бол бид нар энийг ерөөсөө биелүүлж чадахгүй юм байна. Бид нар бол нүүрсгүйгээр амьдарч чадахгүй юм байна. Тийм учраас нэгдэж орохгүй гээд ороогүй л байгаа байхгүй юу. Гэтэл энэ бол манай хувьд бас л хувилбар байхгүй юу. Яг өнөөдрийн нөхцөлд ийм ийм байна. Бид нар ийм ийм ийм болзлыг хангачхаад, тэдэн онд элсээд орж болно гэж бас хэлэх бололцоотой л байхгүй юу. Гэтэл энэ болгоныг бид нар гүйцэд судлахгүйгээр давхиад орчихдог. Тэгээд үүний хамгийн тод жишээ бол бид нар бэлтгэл хангахгүйгээр жишээ нь Дэлхийн худалдааны байгууллагад элсэж орсон. Дэлхийн худалдааны байгууллагад элсэж орохоосоо өмнө бид нар маш олон орнуудтай гэрээ хэлэлцээ хийдэг, тарифаа тохирдог, хүнээ бэлддэг, дотоодын үйлдвэрүүдээ хамгаалдаг арга хэмжээнүүдээ авч байж жишээ нь зах зээлээ Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болж нээдэг гэх мэтийн ийм суурь стратеги ач холбогдолтой конвенцуудад нэгдэхдээ Монголынхоо

урт хугацааны хөгжлийн стратеги, зорилгуудтай нийцүүлж, хамгийн гол нь хэрэгжүүлэх чадвар байна уу, үгүй юу гэдгээ л их сайн тооцоолж л баймаар юм байна лээ. Чадахгүй бол чадахгүй гэдгээ хэлээд л элсэхгүй байх нь бол хамаагүй амар.

Б.Саранчимэг: Ажлын хэсгээс 3 номерын микрофоныг өгье. Өөрийгөө танилцуулаад хариулаарай.

Ш.Цэрэндулам: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбарын хүлэмжийн ялгарлыг бууруулах асуудал бол уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой манай Монгол Улсын тавьж байгаа үндэсний тодорхойлсон хувь нэмрийн нийт ялгаруулж байгаа хүлэмжийн хийний амлаж байгаа амлалтынхаа хүрээнд 50 хувийг нь эзэлж байгаа нэлээн том бууралтын бол салбар байж байгаа. Энэ хүрээнд бид нар 2015-2020 онд ер нь юу хийсэн юм бэ, ямар үр дүнд хүрсэн юм бэ гэдгийг эхлээд танилцуулъя. Мөн 2030 он хүртэл ямар зорилтуудыг тавьж, энэ үүрэг амлалтаа биелүүлэхээр ажиллаж байгаа юм бэ гэдэг талаас нь бол танд танилцуулъя.

1 дүгээрт нь нийт эрчим хүчнийхээ үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлнэ гэдэг ийм зорилтыг бол 2020 он гэхэд 20 хувьд хүргэнэ гэсэн ийм зорилтыг бол тавьсан байсан. 2021 оны 1 дүгээр сарын байдлаар нийтдээ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангагдаж байгаа, эзэлж байгаа хувь 9,1 хувьд хүрсэн, үүгээрээ бол хэрэгжилт 46 хувьтай байна гэсэн 1 дүгээр заалтын хэрэгжилт бол ийм байдалтай бол байгаа.

Мөн суурилагдсан хүчин чадал эзэлж байгаа нөхцөл байдлын хувьд нийтдээ 2020 оны байдлаар бол 17,2 хувь байна гэсэн ийм байдалтай байгаа. Энэ нь бол хэрэгжилт нь бол 86 хувьтай байна гэсэн ийм дүн мэдээлэлтэй байна.

2 дугаарт нь эрчим хүчний үрэлгэн хэрэглээ, дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулна гэсэн 2 дугаар чиглэлийн зорилтууд байж байгаа. Энэ зорилтын хүрээнд Дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэглээг бууруулах, нэн ялангуяа 2023 он гэхэд 11,2 хувиар бууруулна гэсэн ийм зорилтыг бол тавьсан. Үүний хэрэгжилт бол 2021 оны 1 сарын байдлаар нийт дотоод хэрэглээ 13,3 хувиар дамжуулах, түгээх сүлжээний алдагдал бол 13,6 хувиар буурсан. Хэрэгжилт 50 хувьтай байна гэсэн ийм мэдээлэл тайланг бид нар гаргаад ажиллаж байгаа.

3 дугаарт барилгын дулааны алдагдлыг бууруулах эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх гэсэн чиглэлийн ажлууд бол орж ирдэг. Энэ дээр бид нар 2020 он гэхэд нийт барилгын дулааны алдагдлыг бол 20 хувиар бууруулна гэдэг ийм зорилтыг тавьсан. Энэ дээр Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яамнаас өгч байгаа тайлагналын мэдээллээр 2020 оны байдлаар 2 хувиар бол бууруулсан. Нийт хэрэгжилт 10 хувьтай байна гэсэн ийм мэдээлэлтэй бол байгаа. Зам тээврийн дэд бүтцийг сайжруулах 4 дүгээр гол зорилтын хүрээнд сайжруулах замаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хатуу, шингэн түлшний зарцуулалтыг бууруулна гэдэг энэ ажил байж байгаа. Энэ хүрээнд хэрэгжилт бол 96 хувьтай тодорхой хэмжээгээр бас хатуу хучилттай авто замын уртын хэмжээ бас тавьж байгаа зорилтод бол хүрсэн ийм байдалтай бол байгаа. Хэрэгжилтийг би сая маш товчхон танилцууллаа. Ер нь хэрэгжилт харилцан адилгүй заалт бүрээрээ юу гэдэг юм, хариуцаж байгаа яам, түүний оролцоо, тэгээд хэрэгжүүлж байгаа байдал харилцан адилгүй л байна. Одоогийн байж байгаа, тавьж байгаа гол зорилтууд эрчим хүчний салбар дээр эрчим хүчний үйлдвэрлэл сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, түүний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудал дээр 2030 он гэхэд бид нар 30

хувьд хүргэнэ гэдэг ийм зорилтыг бол тавиад ажиллаж байгаа.

2 дугаарт нь бол эрчим хүчний үрэлгэн хэрэглээ дамжуулалт, түгээлт тухайн үеийн алдагдлыг бууруулахтай холбоотой асуудал дээр 9,1 хувьд хүргэнэ гэсэн ийм 2030 он гэхэд бол хүргэнэ гэсэн ийм бас зорилтыг л тавьж ажиллаж байгаа. Гэх мэтчилэн салбар болгон дээр эрчим хүчний салбар дээр тодорхой зорилтуудыг тавиад ажиллаж байна. Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас бол Үндэсний тодорхойлсон хувь тогтолцоог хангасан хэрэгжилтийн ажлын төлөвлөгөө гэж бол гаргадаг. Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг бол бид нар 2030 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөө болгон бас ингэж тодорхой салбаруудын бас үүрэг ролийг бол тодотгон ингэж гаргаж өгсөн байдаг юм.

Б.Саранчимэг: Өнөрболор гишүүн маш тодорхой асуулт асуусан шүү. Ер нь нөгөө хариулахдаа яг нэг юмнууд уншаад явчих биш. Тэр чинь нэг асуултад нь тодорхой хариульа гээд гишүүд өөрсдөө шаардаад байна шүү. Өнөрболор гишүүн тодруульа.

Д.Өнөрболор: Би уг нь маш тодорхой асуусан юм л даа. Миний хайран тодруулгын нэгхэн минут өнгөрчихнө. Тэгэхээр би гол нь яах вэ, хэрэгжилтийг бид нар бол дараа нь юу гэдэг юм ямар түвшинд байгаа вэ гэдгийг зохицуулалт хийчхээж болох байх. Гэтэл таны энэ 50 хувь бууруулаад байгаа гэсэн хэрэгжилтийн эсрэг Эрчим хүчний яамны бодлого ухарч байгаа энэ нөхцөл байдал дээр ямар хариу арга хэмжээ авах юм бэ. Ийм асуудал гарч ирсэн бодлогын түвшинд, стратегийн түвшинд хэлэлцээрийн амлалтад хүрэх нөхцөл байдалд урвуугаар, сөргөөр бодлого явж байна шүү дээ. Тэгэхээр ийм тохиолдолд яах юм бэ Мөнх-Оргил гишүүн ээ. Би бол мэдэхгүй. Яг ний нуугүй хэлэхэд нүүрс бол шууд агуулгаараа Парисын хэлэлцээрийг юу гэдэг юм гарах сөрөг үр дагаврын

нөлөөлөл гэж бол би харж байгаа. Энийг заавал юу гэдэг юм, нүүрс түлэх, түлэхгүй гэдэг асуудлаар шууд тайлбарлаж байгаа юм биш. Тэгэхээр өнөөг хүртэл 50 хувьд хүрчээд байгаа гээд уншиж байгаа.../минут дуусав/

Б.Саранчимэг: Өнөрболор гишүүнд дахиад 1 минут өгье дөө. 3 номер хариулъя.

Ш.Цэрэндулам: Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үндэсний тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороогоороо дамжуулагдаад бид нар бас бодлогын шийдлүүдээ гаргаж ажилладаг. Үндэсний хороо дээр ч гэсэндээ Эрчим хүчний сайд, холбогдох яамдын сайд болон холбогдох төлөөллүүд орж ажилладаг байгаа. Хэрэгжүүлж байгаа төлөвлөгөөн дээр одоо бид нар шууд юу гэдэг юм нүүрсийг ч байдаг юм уу, тодорхой бүтээгдэхүүнийг хориглох ийм заалтыг бол оруулаагүй. Аль болох шилжих, дасан зохицох ийм чиглэлийн төрлийн заалтуудыг оруулсан байгаа гэдгийг бас хэлмээр байна.

Б.Саранчимэг: Өнөрболор гишүүнд 1 минут өгье.

Д.Өнөрболор: Тэгэхээр Монгол улсын олон талт олон улсын гэрээ, гэрээний хоорондын зөвлөмжийн хэрэгжилт тал дээр та нар бол хяналт тавьж байгаа шүү дээ. Тэгэхээр яаж байна гэхээр энэ чинь өөрөө бодлого алдагдаад байна шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол бид нар амлалтаасаа ухраад байна шүү дээ. Тэгвэл ямар нэгэн дүгнэлт гаргадаг ч юм уу, энийг Улсын Их Хуралд энийг бүр хариуцлагатайгаар танилцуулдаг ч юм уу, ямар нэгэн үйлдэл байх хэрэгтэй гэж би хүсээд байна л даа. Тэгэхээр энэ дээр та нар ямар байр суурьтай байгаа юм бэ. Тухайлах юм бол энийг Улсын Их Хурлын гишүүд 4-хөн минутаараа эсэргүүцээд ч байдаг юм уу дэмжихгүй асуудлаараа юу яагаад л

тэгээд л дэмжигдээд явчих юм бол өнөөдөр том агуулгаараа харахад чинь улс орны тийм биз дээ олон улсын өмнө хүлээсэн гэрээ конвенцын хэрэгжилтийн асуудал, амлалтын асуудал хөндөгдөж байна. Нөгөө талаараа гээд тэгэх юм бол 2, 3 сая хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаа ийм асуудал бодлогын түвшинд ухраад байхад чинь та нар зөвхөн өөрсдийгөө хамгаалсан хэлбэрийн.../минут дуусав/

Б.Саранчимэг: Баярлалаа маш тодорхой санал хэллээ. Тэгэхээр бид нар өнөөдөр ганц хэлэлцэх биш. Ер нь хэлэлцдэггүй байсан. Тэгээд өнөөдөр бас том гэрээ, гэрээний зөвлөмж дээр бас хэрэгжилт дээр ажлын хэсэг байгуулаад энийг бас Мөнх-Оргил гишүүн маань яг энийг бас хэрэгжилт дээр нь бид нарт бас танилцуулж байгаад үнэхээр чухал асуудал байна. Тэгээд цаашидаа бид нар яг энэ хэрэгжилт дээр танилцуулдаг биш Өнөрболор гишүүний хэлээд байгаа шиг цаашидаа ямар үнэхээр хэрэгжихгүй бол хэн нь хариуцлага хүлээх юм бэ гээд. Тэгээд дээр манай Байгаль орчны яам илүү их анхааралтай, хариуцлагатай ажиллах хэрэгтэй байна. Тэгээд өнөөдөр тайланг харж байхад ч гэсэн 2020 оны байдлаар гаргасан мэдээллүүд байгаа байхгүй юу. Ядаж 2022 оны сүүлийн байдлаар гаргасан мэдээллүүд гарч ирж болохгүй байсан юм уу. Хэрэгжилтийг хангахад төсөв санхүүгийн хүндрэл болон салбар дундын уялдаа холбоо зохицуулалт хангалтгүй байна гэсэн байгаа. Тэгэхээр энэ хүндрэлүүдийг даван туулахад ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ. Нөгөө талаар бол Монгол Улс аюултай хог хаягдлыг хил дамжуулах, тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелын конвенцод нэгдэн 1996 онд соёрхон батлаад, 1997 оноос мөрдөж эхэлсэн. Гэвч өнөөдрийг хүртэл аюултай хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж чадаагүй байгаа. Тийм ээ. Тэгэхээр нийслэлийн хэмжээнд 27-54 мянган тонн аюултай хог хаягдал гарч байна гэсэн судалгаа байгаа. Тэгэхээр 1960 оноос хойш аюултай хог хаягдлаа

хуримтлуулж тэдгээрийн 85 хувь нь зориулалтын бус газар байна. Тэгэхээр эмнэлгийн болон бусад аюултай хог хаягдлыг хэсэгчлэн авч устгадаг хэдэн компаниуд байдаг ч гэсэн аюултай хог хаягдлыг хүлээж авч булах, аюулгүй болгох, саармагжуулах төвлөрсөн байгууламж өнөөг хүртэл бол Монгол Улсын хэмжээнд байхгүй байгаа. Тэгэхээр ийм байгууламжийг барих газрыг судалж байгаа юу. Энэ ажил ер нь ямар явцтай байгаа вэ гэсэн нэг ийм асуултад хариулт авъя.

Нөгөө талаар түрүүн бас Мөнх-Оргил гишүүн хэлээд байсан. Энэ яг газар тариаланд төрөл бүрийн пестицид ашиглаж байгаа. Тэгэхээр бид нар өөрсдөө Ротердамын конвенцын дагуу хатуу хязгаарлалттай болон хориотой бодис агуулсан пестицидийн асуудал зохицуулагддаг. Одоо бол хөгжилтэй орнууд бараг ерөөсөө энийг хэрэглэхгүй болчихсон. Тэгвэл манай улсад ямар пестицид ашиглаж байгаа вэ гэсэн ийм асуултыг асууя.

3 номерын микрофоныг өгье.

Ш.Цэрэндулам: Саранчимэг гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт нь 2020 оны байдлаар тайлагнал гарсан байна. Ямар учиртай юм бэ гээд. Нэн ялангуяа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой Парисын хэлэлцээрийн хүрээнд тайлагналын хугацаа бол 2015-2020 оны хооронд бол гарч байгаа. Тэр утгаар бол он, сар, өдрийн хувьд бол тийм байдалтай байгаа байх.

2 дугаарт нь төсөв санхүүжилттэй холбоотой конвенцын хэрэгжилтээр ямар чиглэл бодлого баримталж ажилладаг вэ гээд. Ер нь тайлагнал дээр л бид нар тодорхой хэмжээгээр багахан төсөв тавьдагас биш яг хэрэгжилтийн үйл ажиллагаа дээр бас анхаараад тодорхой зориулаад төсөв гаргах боломж бололцоо бол хязгаарлагдмал байдаг. Ерөнхийдөө бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамны

чиг үүргийнхээ хүрээнд л ажлуудаа хийгээд явдаг ийм онцлогтой байгаа.

Б.Саранчимэг: 2 номерын микрофоныг өгье.

Ц.Батжаргал: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе ээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газрын шинжээч Батжаргал байна. Пестицидийн хувьд бол Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.1.3-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайд жил болгон 3 сайдын тушаал буюу Монгол Улсад ашиглаж болох пестицидийн нэр төрөл тоо хэмжээг бол баталдаг. Энэ зохицуулалтаар бол Ротердамын конвенцын хавсралтад орсон буюу бусад улс оронд хэрэглэхгүй болчихсон байгаа пестицидүүдийг бол тухайн нэр төрөлд оруулж баталдаггүй байгаа. Тийм учраас хязгаарласан, хориглогдсон бодисын жагсаалтад орж байгаа пестицидийг бол Монгол Улсад ашигладаггүй ээ гэж ойлгох хэрэгтэй. Тэгээд ер нь бол одоогоор 187 нэр төрлийн пестицидүүдийг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд заасны дагуу 3 сайдын тушаалаар тухайн жилд ашиглах нэр төрөл, тоо хэмжээтэй нь баталдаг. Тусгай зөвшөөрлийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Зөвшөөрлийн хуульд заасны дагуу бол олгоод зохицуулаад явж байгаа.

Б.Саранчимэг: 2 номерын микрофоныг өгье.

Б.Буяннэмэх: Өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны дарга Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгууллагад бол

зөвшөөрөл олгодог. Одоогийн байдлаар бол 10 аж ахуйн нэгж байгууллагад зөвшөөрөл олгосон байгаа. Тухайлбал үүнд эрүүл мэндийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах чиглэлээр бол Элемент, Элемент медикал, Ногоон хариуцлага гэж 3 компани байна. Техникийн хаягдал тос болон дахин боловсруулах, устгах чиглэлээр мөн 3 компани байна. Химийн сав, баглаа боодол, дахин боловсруулах чиглэлээр 2 компани, хаягдал аккумулятор дахин боловсруулах чиглэлээр 4 компани, химийн бодисын хог хаягдлыг устгах чиглэлээр 1, аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах чиглэлээр 1 гэсэн энэ 10 компани маань бол яг саяын энэ 6 чиглэл дотроо давхардсан чиглэлээр ийм зөвшөөрлүүдийг аваад аюултай хог хаягдлыг устгах, дахин боловсруулах чиглэлээр бол үйл ажиллагаа явуулж байгаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ногоон хөгжлийн сэргэлтийн хүрээнд 3 төсөл өргөн барьсны 1 нь бол аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн төсөл байгаа. Энэ төслийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт 20 га газрыг бас аваад энд аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах асуудлаар концессын гэрээний жагсаалтад оруулаад Эдийн засаг, хөгжлийн яаманд бол бид бүхэн өргөн барьчихсан байж байгаа. Энэ төсөл маань концессын зөвлөлийн жагсаалт, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бас энэ асуудал маань хөдөлгөөнд ороод цаашаа явахгаар ийм байдалтай байж байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Саналтай гишүүд байна уу. Ганболд гишүүн саналаа хэлье. Ганболд гишүүнээр тасаллаа.

Г.Ганболд: Би ганцхан санал хэлье гэж бодож байна. Бид нар яах вэ олон улсын конвенцуудад нэгдэж орж байна.

Тэгээд нэгдэж орохын өмнө хэлэлцээрүүд хийх хүрээндээ улсын хүлээх үүргийг нэлээн сайн тооцож байж нэгдэж орохгүй бол сэтгэлийн хөөрлөөр орчхоод, дараа нь хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байдалд орох юм бол зөндөө гарах юм байна. Сая энд хариулж байгааг харахад 2030 онд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ 30 хувьд хүргэнэ гээд ярих шиг боллоо. Тийм ээ. Хэзээ ч бүтэхгүй шүү дээ наадах чинь. Одоо Эрчим хүчний сайд чинь бол наадхын чинь бүр эрс эсрэг байна шүү дээ. Одоогийн Эрчим хүчний сайд. Сэргээгдэх эрчим хүчний хувьд үнэ тарифтай холбоотой тариф өндөр байна. Төвийн эрчим хүчний нэгдсэн системд оруулахад одоогийн бараг бусад эрчим хүчний системүүдийнхээ үнээс 2, 3 дахин өндөр үнээр нийлүүлж байж нэг юм оршин тогтнож байна. Тэгэхээр төрийн бодлого нь Засгийн газрын бодлого нь эрс өөр. Тэгэнгүүт Их Хурал нь олон улсын конвенцод нэгдээд орчихсон. Тэгээд ийм эрс зөрөөтэй балай юманд орж байхын хэрэг ер нь байгаа юм уу. Цаашидаа энэ дээр анхаарахгүй бол энэ эрчим хүчний чинь асуудал бол ноцтой юм шүү дээ. Эсвэл та нар нэгэнт олон улсын гэрээ конвенцод нэгдчихсэн юм бол энийгээ тэр Эрчим хүчний сайд эд нартай ойлгуулж, Засгийн газарт бид нар 2030 он гэхэд ийм үүрэг хүлээчихсэн шүү. Энийгээ биелүүлэхийн тулд Их Хурал бодлого гаргах хэрэгтэй байна. Засгийн газар энэ үүргээ биелүүлэхийн тулд барьж байгаа бодлогоо өөрчлөх ёстой гэдэг дээр шахалт үзүүлэхгүй бол энэ чинь болохоо больчихож байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр зэрэг би бол зүгээр өнөөдөр ийм л юм бодож байлаа л даа. Товчхон тайлан байна. Нэг их дэлгэрэнгүй ч биш юм байна. Ямар үүрэг хүлээсэн юм, тэгээд одоо хэрэгжүүлж байгаа юм юу байгаа юм л гэж байгаа байхгүй юу. Хэрэгжүүлэхэд болохгүй байгаа юмнуудаа л та нар ярих ёстой байхгүй юу. Бид нар ийм үүрэг олон улсын өмнө хүлээчихсэн. Гэтэл бид нар төрийн бодлого юм уу, бид нарын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа маань болохгүй

байна. Тэгээд энийг хэрэгжүүлэхийн тулд Их Хурал, Засгийн гарзаас ийм бодлого гаргаж өгөөч гэдэг ийм л юм оруулж ирэх ёстой байсан шүү дээ. Саяын хэдэн конвенц дээр. Яг саяынхаа жишээн дээр та хэлэх юм бол 2030 онд бид нар ийм үүрэг хүлээчихсэн шүү. Одоо Чойжилсүрэн сайд чинь сэргээгдэх эрчим хүч хөгжүүлэхийн бүр эсрэг 100 хувь эсрэг байр суурьтай байна шүү энийг яах юм бэ гэдэг юм л оруулж ирэх ёстой байхгүй юу. Тэгж ярьж байж үүргээ биелүүлж чадах уу, үгүй юу гэдгээ ярьж байхгүй бол наадуул чинь бүтэхгүй юм байна.

Б.Саранчимэг: Мааш чухал санал хэллээ. Тэгэхээр өнөөдөр бас бид нар ч гэсэн ер нь анх удаа гэрээ, конвенцын олон улсын гэрээ конвенцын хэрэгжилт дээр ярьж байна. Тэгээд цаашидаа бас яам жилд 1 удаа заавал гэрээ конвенцын хэрэгжилтийг бас Байнгын хороо дээр оруулж ирж хэлэлцүүлж байгаарай. Тэгээд манай Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн Мөнх-Оргил гишүүн ажлын хэсгийг ахлаад тогтоол батлуулна гэж байгаа. Тэгэхээр энэ тогтоолд нь бас өөрсдийнхөө саналыг оруулахыг хүсээж байна.

Тэгээд өнөөдрийн Байнгын хорооны хуралд хүрэлцэн ирсэн эрхэм Улсын Их Хурлын гишүүд болоод ажлын хэсэгт баярлалаа. Хурал дууслаа.

14.33 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ